

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-45
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	46-108

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	46-91
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	91-107
3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	108

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
12 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ж.Ганбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, З.Мэндсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан 21 цаг 04 минутаас түр завсарлав.

Хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 08 цаг 24 минутаас үргэлжлэв.

Төсвийн төслийн талаарх Ажлын хэсгийн тусгайлсан саналыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Ж.Золжаргал, М.Мандхай, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Урсгал зардал бууруулах санал.

1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдсэн шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,484.1 сая төгрөгөөр;

-Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг 7,738.1 сая төгрөгөөр;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,901.9 сая төгрөгөөр;

-Дотоодын цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,899.9 сая төгрөгөөр;

-Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,720.5 сая төгрөгөөр;

-Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,238.1 сая төгрөгөөр;

-Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,603.5 сая төгрөгөөр;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг 8,250.1 сая төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг 948.8 сая төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардлыг 650.0 сая төгрөгөөр, нийт 9,848.9 сая төгрөгөөр;

-Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,095.2 сая төгрөгөөр;

МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг 82.9 сая төгрөгөөр;

Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,142.3 сая төгрөгөөр;

-Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг 309.4 сая төгрөгөөр, нийт 40,064.7 сая төгрөгөөр бууруулах.

1.2.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3,000.0 сая төгрөгөөр;

-“Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

-Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг 11,500.0 сая төгрөгөөр;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр бууруулах.

1.3.Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг 6,900.0 сая төгрөгөөр бууруулах;

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг 698.5 сая төгрөгөөр бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал.

2.1.Хавдрын эмнэлгийн барилгын 2025 оны төсвийн жилийн лизингийн төлбөрт 20,000.0 сая төгрөг, тус эмнэлгийн тоног, төхөөрөмжийн зардалд 8,881.7 сая төгрөг, нийт 28,881.7 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж 31,400.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3.Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж 10,000.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын ХХII.2.3.Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,881.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 12
Бүгд: 20
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 12
Бүгд: 20
40.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, С.Одонтуяа нар хуралдааныг түр завсарлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргаж, хуралдаан 09 цаг 26 минутаас түр завсарлав.

Хуралдаан 11 цаг 58 минутаас үргэлжлэв.

Хуралдаан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал хураалтаар үргэлжлэв.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн ажлын хэсгийн гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Урсгал зардал бууруулах санал.

1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдсэн шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,484.1 сая төгрөгөөр;

-Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг 7,738.1 сая төгрөгөөр;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,901.9 сая төгрөгөөр;

-Дотоодын цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,899.9 сая төгрөгөөр;

-Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,720.5 сая төгрөгөөр;

-Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,238.1 сая төгрөгөөр;

-Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,603.5 сая төгрөгөөр;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг 8,250.1 сая төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг 948.8 сая төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардлыг 650.0 сая төгрөгөөр, нийт 9,848.9 сая төгрөгөөр;

-Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,095.2 сая төгрөгөөр;

МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг 82.9 сая төгрөгөөр;

Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,142.3 сая төгрөгөөр;

-Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг 309.4 сая төгрөгөөр, нийт 40,064.7 сая төгрөгөөр бууруулах.

1.2.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3,000.0 сая төгрөгөөр;

-“Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

-Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг 11,500.0 сая төгрөгөөр;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр бууруулах.

1.3.Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг 6,900.0 сая төгрөгөөр бууруулах;

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг 698.5 сая төгрөгөөр бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал.

2.1.Хавдрын эмнэлгийн барилгын 2025 оны төсвийн жилийн лизингийн төлбөрт 20,000.0 сая төгрөг, тус эмнэлгийн тоног, төхөөрөмжийн зардалд 8,881.7 сая төгрөг, нийт 28,881.7 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж 31,400.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3.Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж 10,000.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын ХХII.2.3.Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,881.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй саналаа татан авав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Ж.Золжаргал, М.Мандхай, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Урсгал зардал бууруулах санал.

1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдэхээр тооцсон шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,484.1 сая төгрөгөөр;

-Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг 7,738.1 сая төгрөгөөр;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,901.9 сая төгрөгөөр;

-Дотоодын цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,899.9 сая төгрөгөөр;

-Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,720.5 сая төгрөгөөр;

-Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,238.1 сая төгрөгөөр;

-Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,603.5 сая төгрөгөөр;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг 8,250.1 сая төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг 948.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 650.0 сая төгрөгөөр, нийт 9,848.9 сая төгрөгөөр;

-Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,095.2 сая төгрөгөөр;

-МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг 82.9 сая төгрөгөөр;

-Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,142.3 сая төгрөгөөр;

-Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг 309.4 сая төгрөгөөр, нийт 40,064.7 сая төгрөгөөр бууруулах.

1.2.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3,000.0 сая төгрөгөөр;

-“Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

-Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг 11,500.0 сая төгрөгөөр;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах.

1.3.Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг 6,900.0 сая төгрөгөөр бууруулах;

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг 698.5 сая төгрөгөөр тус тус бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал.

2.1.Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах эхний удаагийн төлбөрт 17,000.0 сая төгрөг, тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардалд 6,881.7 сая төгрөг, нийт 23,881.7 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж 31,400.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3.Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж 10,000.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын ХХII.2.3.Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,881.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.5.Эрчим хүчний бодлогын шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх сайдын төсвийн багцад 5,000.0 сая төгрөг нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Засгийн газрын тусгай сангийн нийт зардлыг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Боловсролын зээлийн сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 33,604.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, тус сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Засгийн газрын тусгай сангийн нийт зардлыг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 40,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, тус сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.2.1.Батлан хамгаалах салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 27,975.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 5,938.2 сая төгрөгөөр бууруулж, Батлан хамгаалах салбарын тоног төхөөрөмжийн зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Ойжуулалт хөтөлбөрийн зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, мөн сайдын их засварын зардлыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.52.Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 46,659.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,909.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.22.Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 3,599.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,257.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,940.2 сая төгрөгөөр, XVI.1.1.5.Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 41,089.4 сая төгрөг, санхүүжих дүн 16,435.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, энэ эх үүсвэрээр “Хушаат сумын улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын дуусгал /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 13,880.4 сая төгрөг, санхүүжих дүн 6,940.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.130.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 4,800.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 5,969.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:

Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.3.2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 165.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн академийн тоног төхөөрөмж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг 1,556.7 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 2
Бүгд: 22
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг 694.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтийн 22.6.2.4.“Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж, хэмжих нэгжийг “тоо” гэж, Суурь оныг “2023” гэж, Суурь түвшнийг “0” гэж, Зорилтот түвшнийг “1” гэсэн арга хэмжээ нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Дархан-Уул, Хонгор сум/” гэснийг “Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Дархан-Уул, Хонгор сум/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 14
Бүгд: 22
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 22.6.1.1 дэх заалтыг “Монгол Улсын бүх хот суурин буюу хүн ам төвлөрсөн газруудад озон, PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу

исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэмжих” гэж, суурь оныг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 22.6.1.2. дахь дэд заалтыг “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдэд агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтэд “30.8.1.2.Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь” гэж, хэмжих нэгжийг “хувь” гэж, суурь оныг “-” гэж, Суурь түвшинг “-” гэж, Зорилтот түвшинг “10” гэсэн арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, өөрийн гаргасан 2 зарчмын зөрүүтэй саналаа татаж авав.

6.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Улаанбаатар хотын төвлөрлийг задлах зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа хувийн сургуулиудын хувьсах зардлыг 38,500.0 сая төгрөгөөр бууруулж, Хөдөө орон нутгийн дотуур байрны хангамжийг сайжруулах, нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 38,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 22
Бүгд: 22
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн 13.1.4 дэх заалтад “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн”-гийн нэршлийг “Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 15
Бүгд: 22
31.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын урсгал зардал дахь Өргөн нэвтрүүлэх хөгжүүлэх сангийн бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын сайдын урсгал зардал дахь сургуулийн өмнөх боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилтийг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22
4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, суурь түвшин “35281” гэснийг “172963” гэж, 2025 оны зорилтот түвшин “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 14
Бүгд: 22
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.1 дэх дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “5” гэснийг “3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.2 дахь дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “16” гэснийг “12” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.2.1 дэх дэд заалтын суурь түвшин “9386” гэснийг “1126” гэж, 2025 оны зорилтот түвшин “10500” гэснийг “1200” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.3.2 дахь дэд заалтын суурь түвшин “36” гэснийг “16.7” гэж, 2025 оны зорилтот түвшин “40” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.6.1.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Нийт гэр бүлд гэрлэлт цуцлалтын эзлэх хувь хэмжээ” гэснийг “Нийт гэр бүлд гэр бүлийн талаарх сургалтад тэнхим, цахимаар хамрагдсан гэр бүлийн эзлэх хувь”, суурь түвшин “2.2” гэснийг “0” гэж, 2025 оны зорилтот түвшин “<2.2 буурна” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 12
Бүгд: 22
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нийслэлийн Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 15.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нийслэлийн Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төрийн албан хаагчийн цалинг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг хэмнэсэн 219.0 тэрбум төгрөгийг Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах. Үүнд:

- 1/Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл
- 2/Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл
- 3/Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл
- 4/Улаанбаатар хотын төвийн дулаан хангамжийн төсөл

5/Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22
4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, өөрийн гаргасан 1 зарчмын зөрүүтэй саналаа татаж авав.

17.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн” гэснийг “Байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо” гэж, 2025 оны зорилтот түвшин “14564” гэснийг “15154” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 15

Бүгд: 22

31.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 2025 онд шинээр нэмэгдэх орон тоог 30 хувиар бууруулж, буурч байгаа орон тоотой холбоотой бусад урсгал зардлыг холбогдуулан бууруулах замаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг бууруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын XI.1, XI.2, XI.3, XI.4, XI.5, XI.6 дахь хэсгийн “тоног төхөөрөмж”-ийн төсөвт өртөг болон санхүүжих дүнг нийт 21,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 21

Бүгд: 22

4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 9,800.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны норматив зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 18

Бүгд: 22

18.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 991.0 сая төгрөгөөр бууруулж, Авлигатай тэмцэх газрын даргын томилолтын зардлыг 533.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 112.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 345.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22

4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 620.5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын томилолтын зардлыг 420.5 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 200.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 22
Бүгд: 22

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Сангийн яамны хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 5,065.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг дараах дурдсан дүнгээр нэмэгдүүлэх. Үүнд:

1.Цагдаагийн ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 2,900.0 сая төгрөгөөр;

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 245.0 сая төгрөгөөр;

3.Хил хамгаалах ерөнхий газрын байр ашиглалтын зардал 1,000.0 сая төгрөгөөр;

4.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас санхүүжилтийг 920.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22

4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

23.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын Хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 4,055.0 сая төгрөгөөр бууруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 22
Бүгд: 22

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

24.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах” гэсэн агуулгатай 38.1.2.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “780” гэж, Зорилтот түвшин “300” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 17.1 дэх заалтын 17.1.1 дэх дэд заалтад “төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт” гэсэн агуулгатай 17.1.1.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “20” гэсэн арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.25.Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.18 км хатуу хучилттай автозамын санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Баянхонгор аймгийн төвд баригдах Дулааны цахилгаан станцын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээний санхүүжих дүн 3,000.0 сая төгрөгөөр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 13
Бүгд: 22
40.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

27.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 18.1 дэх заалтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого, төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

28.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он: “2023” гэж, Суурь түвшин: “-” гэж, Зорилтот түвшин: “200” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

29.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийг 400.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургах, стандартыг ашиглаж хэвшүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох төсөлд 400.0 сая төгрөгөөр Эрчим хүчний сайдын урсгал зардалд нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

30.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл нарын гаргасан, Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийн 11,986.1 сая төгрөгийг 9,000.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22

4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.5-д сургуулийн барилга 640 суудал, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 34 дүгээр хороо, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 15,795.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 11,975.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 1,800.0 сая төгрөгөөр бууруулж, сургуулийн өртгөлийн барилга 320 суудал, Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр сургууль, хэрэгжих хугацаа 2019-2027 он, төсөвт өртөг 7,113.1 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг

гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах гэсэн зарчмын зөрүүтэй саналаа татаж авав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн байнгын хорооны Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 6.1.1.1 дэх дэд заалтын “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн хувь” гэснийг “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 7.1.5.1 дэх дэд заалтын “Хууль тогтоомжийн хэрэгжилт” гэснийг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 7.1.8 дахь заалтын “Зөвлөмжийн хэрэгжилт” гэснийг “Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 11.1.1.1 дэх дэд заалтын “суурь он 2022” гэснийг “суурь он 2023” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн хавсралтын XIV.1.4.1.Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, био технологийн сургуулийг Дархан, Сэлэнгийн бүс рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Төвийн бүс/ гэснийг 800.0 сая төгрөгөөр, XIV.1.4.2.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн

Механик, тээврийн сургуулийг Хөшигийн хөндий рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Хөшигийн хөндий/ гэснийг 800.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн зардлыг 1,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 15
Бүгд: 22
31.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Төслийн хавсралтын XVI.1.1.2.Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний 2025 оны санхүүжих дүнгээс 2,000.0 сая төгрөгөөр, XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний 2025 оны санхүүжих дүнгээс 7,950.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, Налайх-Чойр чиглэлийн авто замаас Баянцагаан сум хүртэлх хатуу хучилттай 64.4 км авто замын эхлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 33,017.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний 2025 оны санхүүжих дүнг 9,950.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 12
Бүгд: 22
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн хавсралтын “Сервис центр-2” дэд бүтцийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 14, 16, 18 дугаар хороо/, төсөвт өртөг 6,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,039.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Ногоон гудамж, дэд бүтэц /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, төсөвт өртөг 2,898.3 сая төгрөг, санхүүжих дүн 898.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 7.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн хавсралтын “Сервис центр-2” дэд бүтцийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 14, 16, 18 дугаар хороо/, төсөвт өртөг 6,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,039.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Ногоон гудамж, дэд бүтэц /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, төсөвт өртөг 2,898.3 сая төгрөг, санхүүжих дүн 898.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Төслийн хавсралтын XVI.1.1.75.Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомтын хүртэлх хатуу хучилттай авто зам төслийн санхүүжилтээс 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын хөтөлбөр, арга хэмжээний Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 14
Бүгд: 22
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Төслийн хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/ гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 9,816.6 сая төгрөгөөр бууруулж, Барилга үргэлжлүүлэн барих 2019 онд эхэлсэн Өмнөговь, Цогтцэций сум, 960 хүүхдийн сургуулийн барилга мөн дүнгээр 9,816.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Төслийн хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ гэсэн төслийн 33,533.9 сая төгрөг гэсэн дүнг бууруулж, Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай автозамын дуусгал /Говийн бүс/ гэсэн төслийн санхүүжих дүнг 33,533.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Төслийн хавсралтын XVII.1.1.3.Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөгөөр бууруулж, Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/, төсөвт өртөг 1,845.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөг гэж нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 11.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Төслийн хавсралтын XVII.1.1.3.Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөгөөр бууруулж, Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/, төсөвт өртөг 1,845.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөг гэж нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 11.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Төслийн хавсралтын XVII.1.1.3.Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөгөөр бууруулж, Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/, төсөвт өртөг 1,845.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөг гэж нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны

Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт тухай хуулийн төсөл

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг мэдэгдэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 22.5.22 дахь заалтын “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 11.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	9
Бүгд:	22

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22.14 дэх хэсгийн “үйл ажиллагааны орлогод үзүүлэх бусад” гэснийг “үйл

ажиллагааны орлогын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтад доор дурдсан агуулгатай 22.15 дахь хэсэг нэмэх.

“22.15.Энэ хуулийн 22.5.22-т заасан импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 27.11 дэх хэсгийн “холбогдох олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид үндэслэн тооцож, зөвлөмжийн хамтаар” гэснийг “Монголбанкнаас зарласан тухайн татварын жилийн дунджаар тооцож, дараагийн татварын жилийн 1 дүгээр сард багтаан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайныг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 7

Бүгд: 22

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 38.7 дахь хэсэг нэмэх:

“38.7.Энэ хуулийн 38.4-т заасан татварын хөнгөлөлтөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, түүний тодорхойлолтыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 6

Бүгд: 22

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 7

Бүгд: 22

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг мэдэгдэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн “Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг мэдэгдэв.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 18
Бүгд: 22
18.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.9 дэх заалт нэмэх:

“15.1.9.байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр, бусад тэмдэглэх өдрийг тэмдэглэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Арав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн тэмдэглэх хэсэгт Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “, цаашид өөрчлөгдөхгүй байх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9

Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “, цаашид өөрчлөгдөхгүй байх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/“бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, ур чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистик гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуульд тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид “бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” болон “бусад зардал” гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

“4.Төрийн байгууллагуудын мэдээллийн системүүд, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“5.Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид нүүлгэх, нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судалж, жагсаалтыг гаргаж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж, холбогдох шийдвэр гарсны дараа худалдах, худалдан авах

ажиллагааг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

“6.Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын талаар нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмэх:

“7.Төсвөөс олгож буй бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих болон төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж, 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Сангийн сайд Б.Жавхлан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 17
Бүгд: 22
22.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 12
Бүгд: 22
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

“8.Цэвэр эрчим хүч, хогноос эрчим хүч гаргах асуудлыг зохицуулах, дэмжих, ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9 дэх дэд заалт нэмэх:

“9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дэх заалтын “-Ургамал хамгааллын газар” гэсний дараа “, Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Төмөр замын газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 17
Бүгд: 22
22.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван хоёр. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг мэдэгдэв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион

байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 12
Бүгд: 22
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж, аудитын тайлан, Тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 10

Бүгд: 22

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4/шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, Бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 7

Бүгд: 22

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 11

Бүгд: 22

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 7

Бүгд: 22
68.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6/аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг

алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, О.Саранчулуун, Ж.Чинбүрэн нарын гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, О.Саранчулуун, Ж.Чинбүрэн нарын гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмэх:

“7/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дэх заалтад “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 14
Бүгд: 22
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан, Төслийн 1 дэх заалтад “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Кино урлагийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төсөлд доорх агуулгатай 4 дүгээр заалт шинээр нэмэх:

“4.Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн Боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй, эсвэл Улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж, өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 16
Бүгд: 22
27.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр заалтын 5 дахь дэд заалт “а”-аас “сургууль, цэцэрлэг дотуур байрны хоолны материал худалдаж авах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22
9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “а” заалтаас “Боловсролын салбарын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг дотуур байрны

хоолны материал худалдаж авах” гэснийг хасаж, “Гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн сурагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 16
Бүгд: 22
27.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хорооны Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх боломжийг бүрдүүлэх, үүнд шаардлагатай Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулахыг даалгах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Тэмүүлэн нарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

“8/Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалттай шаардлага хангасан барилгыг хууль тогтоомжид нийцүүлэн 5 жилийн дотор өөрийн өмчлөлд эцэслэн шилжүүлж авах нөхцөлтэйгөөр санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, худалдан авахыг Засгийн газарт даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийн код өгөх, дугаар, ангилал, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнтэй уялдуулж, төсөвт өртгийг өөрчлөх. Мөн төслүүдийн зүйл, хэсэг заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван гурав.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл

Төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван дөрөв.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл

Төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 6 цаг 47 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 88.0 хувийн ирцтэйгээр 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 14 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
18 цаг 12 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Асуудал маань хүлээгдэж байгаа учраас хуралдааны цагийг сунгая. Хуралдах цагаа 6 цагаас хойш сунгаж байна. Сунгаж хуралдах гэж байна. Жавхлан сайд танилцуулгаа хийнэ, та 2 яагаад, хурлаа эхэлье. Төсвийн хоёр дахь хэлэлцүүлгээ хэдүүлээ явуулчихъя. Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааныг эхлүүлье. Ирц 52 хувьтай байна. Гишүүдийнхээ ирцийг танилцуулъя. Тилеуханы Аубакир гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Дамбын Батлут гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Ринчиндоржийн Батболд гишүүн, Хөхүүгийн Болормаа гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүд оролцож байна.

Ингээд би хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Эхлээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг, 2 дугаарт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг, 3-д Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Эхлээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн, үгүй ээ тэрийг дараа нь хийчихье. Одоо энийг яагаад орчихье. 25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхлүүлье.

Ажлын хэсэгт Болдын Жавхлан Сангийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууны Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний

аудитын газрын Гүйцэтгэх-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батнямын Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн хүмүүс оролцож байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье. Та хэлэх үү микрофон.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн дахин өргөн барилаа.

Төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчмыг баримталлаа. Үүнд, 1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-ноос төсвийг нь хянаж, төсвийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн байгууллагууд болон ХЭҮК зэрэг байгууллагуудын урсгал зардлыг өмнөхөөр нь өргөн барилаа.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь бууруулна. А.Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт

ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулах. Б.Соёлын эрхийн бичиг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулъя. В.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгчийн хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулъя. Г.Улсын төсвийн хөрөнгө оруулалт, хөрөнгөөр шинээр энэ биш шүү, уучлаарай. Д.Дээр дурдсан 50-аас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан, ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана. Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулъя. 5.Зарим эх үүсвэр, ТЭЗҮ, зураг төсөл, тоног, төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатанд байгаа төслийг хойшлуулъя. 6.Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатанд байгаад үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийг зээлийн ашиглалтыг хойшлуулъя. 7.ХСҮТ 2 төслийг шинээр нэмж тусгалаа. Өргөн барьсан төсөвт шинээр нэмэгдэж байгаа цорын ганц хөрөнгө оруулалтын төсөв нь энэ болно.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувь, нийт зардал ба цэвэр зээлийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж байна. Суурь тэнцэл ДНБ-ий 3,3 хувийн эерэг болохоор байна.

Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 5 номерын микрофоныг.

Д.Загджав: Та бүхэндээ энэ оройн мэндийг өргөн дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр бүхэлд нь хориг тавьсан нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна. Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьжээ.

2025 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах Сангийн сайд, Монгол Улсын ерөнхий аудитор, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд нарын 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 21 их наяд 281,3 тэрбум төгрөгөөр, зарлагыг 5 их наяд 208,9 тэрбум төгрөг тус тус төлөвлөжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. 1.Эдийн засгийн гадаад хүчин зүйлийн нөлөөлөл, уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалж, нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төслийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3.Цахим систем, ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэстэй тооцож, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зарлагыг хумьж, зарим хэрэгжиж эхлээгүй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг багасгах эрсдэл үүсгэх магадлалтай байна.

5.Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна, Монгол Улсын Үндсэн хууль түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжид нийцэхгүй байгаад анхаарал хандуулахыг та бүхнээс хүсье.

7.Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу бүх шатны төсөв захирагчид аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, анхаарч ажиллах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Хууль санаачлагч Сангийн сайд болон Монгол Улсын Ерөнхий аудитораас асуух асуулттай гишүүн байна уу? Нэрсээ өгье. Мэндсайхан гишүүнээр тасалъя. Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Оройн мэнд гишүүдээ. Энэ танилцуулгын дараа ер нь ажлын хэсэг, дээрээс нь зарчмын зөрүүтэй саналуудыг санал хураагаад шууд явчих юм шиг байна. Тийм болохоор нэг үг хэлэх боломж олдохгүй юм шиг байна. Тийм болохоор нэг хэдхэн үг хэлээдэхье. Би нөгөө төсвийн ажлын хэсэгт орж чадаагүй. Тэгээд өчигдөр хөөцөлдөж байж 2 ажлын хэсэгт халти суусан. Өнөөдөр ажлын хэсгийн хуралдаан дээр нэг ороод гарсан. Ажлын хэсгийнхэн маань энэ ажлын хэсэгт ороогүй гишүүд гарч байх уу, тэгж байгаад бид ярих уу энэ тэр гэсэн нэг сонин юм яриад эхэлсэн. Тэгэхээр ажлын хэсэг бол их нууц байдалтай их мундаг ажил хийгээд байгаа юм болов уу гэж бодоод байна.

Тэгээд ер нь яах вэ будаач, будаач гэхээр хасаж болно, тэгэхдээ будаач, будаач гэхээр сахлаа будчихлаа ч гэдэг. Нөгөө жоомоо алах гэж байгаад гэрээ шатаачихлаа ч гэдэг. Тэгээд хасахдаа нэг жоохон бодолтой хасмаар юм шиг юмнууд харагдаад байна энд. Энэ ажлын хэсгийнхэн оруулж ирж байгаа төсөл дээр энэ цэрэг, цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр, онцгойтой холбоотой асуудлуудыг ер нь хасаад ороод ирэх юм шиг байна. Тэгээд санал хураалгах юм шиг байна. Би энэ дээр бол ер нь эсрэг байр суурьтай байгаа шүү. Дотоодын цэрэг, цагдаа чинь ерөөсөө хүн хүчээ нэмэгдүүлэхгүй бол болохгүй байгаа, орон тоо нь байнга дутуу ажиллаж байдаг ийм салбар байгаад байдаг. Ямар хүнд нөхцөлд

ажиллаад байна вэ гэдгийг та нар өөрсдөө уг нь бодоод үзмээр байгаа юм. Шүүхийн шийдвэр ч гэсэндээ хэдэн хүн нэмье гээд ороод ирсэн тэрийг нь хасчихсан.

Тэгэхээр шүүхийн шийдвэр надад өгсөн танилцуулгаар ер нь 1380 хүний орон тооны дутагдалтай ажиллаж байгаа гээд байдаг. 20 хоригдол гэх юм уу эрхээ хязгаарлуулсан хүнийг 1 хянагч хянаж байх ёстой юмыг өнөөдөр 100-аас 150 хүнийг хянаад байж байна гэж байгаа юм. Энэ дээр эрсдэл үүсвэл хэн хариуцах юм бэ? Орон тоог нь нэмээгүйгээрээ бид хариуцах юм уу, тэр хариуцаж байгаа шүүхийн шийдвэр нь өөрөө хариуцах юм уу гэдэг асуудал үүсээд явна. Тэгээд цагдаагийн байгууллага ер нь 6000 хүний орон тооны дутагдалтай гээд байдаг. Түрүүчийн бид нарын энэ батлаад хасагдчихсан төсвөөр 2000 хүний орон тоо уг нь батлагдаад явсан юм байна лээ. Тэгээд багасга гэхээр мянга хэдэн зуу ороод ирж байгаа юм. Тэрийг нь өнөөдөр бүүр байхгүй болгох гээд ингээд яриад байна. Энийгээ жоохон авч үзээч гэдэг зүйлийг энэ Байнгын хорооны гишүүддээ л уриалмаар байна. Энийг битгий дэмжээрэй гэдэг юм.

Тэр эрчим хүчний реформтой холбоотой 9 тэрбумыг яриад бүүр сүйд болсон. Энэ уг нь задаргаатай юм байна лээ шүү дээ. Энийг яагаад задаргааг нь гишүүддээ өгөөд харуулчхаагүй юм бэ гэдэг юмыг би бас нэг. Тийм, 8,8 тэрбум байгаа шүү дээ, бараг 9. Энэ чинь дотроо задаргаатай, зөндөө л юм явж байгаа юм байна лээ. Тэгээд задаргааг нь өгөхгүй ингээд нэг бөөн хэл ам болгоод ингээд нийгмээрээ нэг юм болгоод явчих юм. Тэгээд эд нар дээр жоохон анхаараарай. Хасах юмаа хасъя, хасаж болж байна. Тэгэхдээ.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Мэндсайхан гишүүн асуултаа асууя. Хариулт байхгүй, санал юм байна тийм ээ? Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

З.Мэндсайхан: Би Батболд гишүүнтэй адил саналтай байгаа юм. Ер нь энэ 2025 оны төсвийн төслийг харахаар төсөв томорчихсон байна, тэллээ гээд л бид яриад байгаа юм. Бид нэг асуудлыг ерөөсөө ярихгүй яваад байна. Энэ Монгол Улсын сайд нар энэ салбарыг толгойгоороо хариуцна гэж бүгдээрээ Их Хуралд тангараг өргөж сайд болсон. Тэгээд бүгдээрээ ажлаа хийж чадахаа байчихсан юм уу? Хоорондын уялдаа холбоог хангах Үндэсний хороо гэдэг юмнууд гараад ирчихсэн. Сайд салбарынхаа ажлаа хийж хариуцаж, Их Хурлын өмнө, Ерөнхий сайдынхаа өмнө хариуцаж чадахаа байгаад, үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байсан учраас ингээд Үндэсний хороонууд гэж хооронд нь уялдуулдаг, зохицуулдаг ийм нэг бүтэц гарч ирсэн байна. Тэгээд энэ ажлын албатай. Яг нийтдээ хэчнээн Үндэсний хороо байдаг юм бэ?

Ийм маягаар бид энэ урсгал зардал, орон тоог тэлээд байдаг. Зайлшгүй нийгмийн өмнө хууль хүчийг сахиулах, нийгмийн хэв журмыг сахиулах, иргэдийнхээ аюулгүй, тайван байдлыг хангах ёстой цагдаагийн дарга нь өчигдөр зовлон яриад сууж байна лээ шүү дээ. 6000 орон тоо байхгүй гээд. Тэгээд энэ асуудлыг нь хасна гээд ороод ирж байна. Тэгэхээр энэ том бүтцээ өөрчлөхгүйгээр бид цаашаа ингэж явах боломжгүй юм байна гэдэг нь харагдаад байгаа байхгүй юу. Энэ чинь 23 сайд байна шүү дээ Ерөнхий сайдтайгаа нийлээд. 23 сайд салбараа хариуцаад, ажлаа хийж чадахаа байгаад яг хэчнээн Үндэсний хороо байна вэ? Энийг нэг хэлээд өгөөч. Хэчнээн ажлын албанд нь хэчнээн хүн ажиллаж байна вэ?

Хөдөө аж ахуйн сайд Шинэ хоршоо хөдөлгөөнийг Шадар сайд дээр Үндэсний хороо байгуулагдаад ажиллаж байна. Батсуурь сайд ажлаа хийж чадахгүй байгаа юм уу Барилга, хот байгуулалтын үндэсний хороо гэж гараад ирчихсэн. Орон сууцжуулах үндэсний хороо гэж. Үгүй ээ энэ яг ямар учиртай юм бэ? Энэ сайдууд чинь ажлаа хийдэггүй юм уу? Тэгээд Хурдасгуур төв гээд орон сууцны судалгаа хийгээд зогсож байдаг ийм төв ороод ирчихсэн. Ажлын хэсэг энэ Үндэсний хороодын ажлын хэсгийг хооронд нь уялдуулах дэд ажлын хэсэг гэж бараг гарч ирэх юм шиг байна. Ийм маягаар завхарч болохгүй. Энэ шаардлагатай орон тоо ялангуяа хууль хүчний байгууллагуудын орон тоог хасна гэдэг асуудал байж болохгүй шүү гэдгийг би Байнгын хорооныхоо гишүүддээ уриалах гэсэн юм.

Сангийн яамнаас энэ хороодын тоог нэг, тэр ажлын албанд нь ажиллаж байгаа хүмүүсийн мэдээллийг. Хэрэг эрхлэхээс авъя гэж бодож байна. Энэ яг ямар учиртай ингээд салбар хариуцсан сайд нарынхаа хооронд ийм уялдаатай ийм бүтэц гаргаж ирээд байгаа юм бэ гэдгийг?

Ц.Даваасүрэн: Тэр үндэсний хороодыг хэдэн номерын микрофон хариулах гэж байна вэ? Цагдаагийн байгууллагын орон тооны асуудал яригдаад байгаа юм байна сая гишүүдийн ярианаас. Өмнө бид шүүх, прокурорыг хоёр дугаар хэлэлцүүлэг явчихсан хойно хөл алдаж нэмчхээд, цагдаагаа гадуурхаад байж болохгүй шүү, зохисгүй харагдана шүү. Энийг гишүүд анхаарна биз. 2 дугаар хэлэлцүүлэг явчихсан байхад 70, 80 тэрбумаар нь шүүх, прокурорыг нэмсэн шүү дээ. Тэгэхдээ цагдаагаа хөл, гар болж байгаа цагдааг нь хасаад байх юм бол утгагүй л харагдана л даа. Хэдэн номерын микрофон юм бэ? Хэрэг эрхлэхээс байна уу? Тэр үндэсний хэдэн хороо байна гээд байна шүү дээ. Сангийн яамнаас мэдэж байгаа хүн байна уу? Та нар ч гэсэн төсвөө хянаж байгаа юм чинь мэдэж л байгаа шүү дээ. Миний ойлгож байгаагаар зарим хороодын цалин яг төслийн цалингуудын жишигтэй байгаа шүү. Зүгээр төрийн албан хаагчийн биш шүү дээ бүр төслийн цалингийн жишигтэй байгаа. Сангийн яамнаас хариулчих, хэд байгаа юм бэ? 8 номерын микрофоныг өгчих.

М.Санжаадорж: Үндэсний хорооны тоог төсвийн программаас харж байгаад танд дараачийн асуулт дээр хэлэхгүй бол шууд хэлэх боломжгүй байгаад байна.

Ц.Даваасүрэн: Тэгвэл санал хураалт, гишүүд танилцуулгатай холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэгийн дагуу зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгах ёстой. Тэгээд нөгөө ажлын хэсгийн санал яг эцэслэгдээгүй байгаад байгаа юм байна. Сангийн сайд орохгүй бол Сангийн сайдыг нэг эцэслэхэд нь саналаа хэлээч гэж байгаа юм байна. Тэгээд түр хэдүүлээ завсарлаад, одоо санал ороод ирэнгүүт санал хураалтаа эхэлье. Нөгөө санал нь орж ирээгүй байгаа юм байна. Эхлээд нөгөө ажлын хэсгийн саналууд зарчмын саналуудаа хурааж байж явахгүй бол дараагийнх нь болохгүй.

Давхардсан санал гарчихвал эхний санал хураалтаараа явдаг байхгүй юу. Засгийн газрын Хэрэг эрхлэхээс хүн байна уу? Тийм байна шүү дээ, сайд нь байж байна шүү дээ, сайд хариулъя. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын энэ үндэсний хороо, зөвлөлүүд бол олон улсад хүлээсэн үүрэгтэй зөвлөл, хороод салбарын яамнуудын дэргэд ажилладаг. Гэхдээ Үндэсний хороо болгон өөр

өөрсдийн ажлын албатай гэсэн үг огт биш. Сая шинэ Засгийн газар байгуулагдаад энэ Үндэсний хороо, зөвлөл чинь бараг 80 гаруй байсан. Түүнийг нь багасгаад жишээ нь Алсын хараа 2050 үндэсний хороонд гэхэд 30 орчим Үндэсний хороо зөвлөлүүдийг нэгтгэсэн. Ингээд нэг л Үндэсний хороотой болгоё гээд ингээд шийдвэрлэсэн. Зайлшгүй жишээ нь Шинэ хоршоо хөдөлгөөн гээд өнгөрсөн хугацаанд зохион байгуулагдаж байсан юм гэхэд үүнийг нөгөө салбар дундын уялдаа гэдэг утгаар нь шинэ хороо Үндэсний хороо байгуулаад явдаг ийм жишээнүүд байгаа. Жишээ нь Нээлттэй засгийн үндэсний зөвлөл гэхэд л Нээлттэй засгийн үндэсний зөвлөлийн гишүүн орон гэдэг утгаараа ийм зөвлөл заавал тухайн салбарын сайд нь ахалж явах ёстой гэдэг утгаараа ингээд аваад явдаг. Тэрнээс биш Үндэсний хороо болгон өөр өөрсдийн ажлын албатай гэсэн үг огт биш гэдгийг хэлэх ёстой.

Одоогийн байдлаар яг өөрийн ажлын албатай 3-аас 10 хүн, 2 хорооны хувьд 15 хүн ажилладаг, бусад нь 15 хүн орчим. Жишээ нь агентлаг байж байгаад буулгачихсан Цөмийн энергийн комисс гэхэд яг ийм үндэсний хорооны статустайгаар ингээд жишээ нь үйл ажиллагаагаа явуулж байгаа байхгүй юу. Ингээд аваад үзэхээр бол одоо яг ажлын албатай, яг хүн цалинжуулаад явуулж байгаа үндэсний хороо гэвэл 7, 14 ийм Үндэсний хороо байгаа. Энэ өөрөө ажлын албатай. Бусад зөвлөл, үндэсний хороо жишээ нь уур амьсгалын чиглэлийн, баяр наадмыг зохион байгуулах, Үндэсний тээврийн хороо, Олимпын хороо, Нээлттэй засгийн түншлэлийн зөвлөл, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл ч гэдэг юм уу, Кибер аюулгүй байдлын зөвлөл, Залуучуудын зөвлөл энэ тэр гээд ийм зөвлөлүүд зүгээр сайд ахалж байгаа болохоос биш дэргэдээ ажлын алба байгуулаад, бие даасан бүрэлдэхүүнтэй, төсөв мөнгөтэй ажиллаж байгаа зүйл огт байхгүй гэдгийг хэлэх ёстой байх гэж бодож байна.

Тийм учраас өнгөрсөн үеийг бодох юм бол Үндэсний хороо, зөвлөлүүдийг нэлээд нэгтгэсэн. Ерөнхий сайд Алсын хараа 2050 Үндэсний хорооны л дарга хийж байгаа. Тэрнээс биш энэ хороонд хуучин бол хуулиараа дандаа Ерөнхий сайд ахалдаг, салбарын сайд ахалдаг ийм зөвлөл, хороод бий болчихсон байхгүй юу. Тэгэхээр салбарын хуулиудыг дагалдуулаад дандаа ийм үндэсний зөвлөл, хороодыг байгуулчихдаг. Тэгээд түүнийг нь Засгийн газар ингээд Ерөнхий сайдын захирамжаар ч юм уу, Засгийн газрын тогтоол гаргаад байгуулаад явахгүй болохоор болдоггүй. Тэгэхээр 30 орчим хороо нийлээд Алсын хараа 2050 үндэсний хороо болсон. Бусдаар шинэ үндэсний хороо байгуулаад, тэгээд шинэ ажлын алба бүрдүүлээд яваад байгаа зүйл байхгүй гэдгийг хэлэх ёстой. Мэндсайхан гишүүний энэ саналыг дэмжиж байна.

Төрийн жинхэнэ албан хаагч нарыг шууд авч ажиллуулах гэхээр, орон тоон дээр авч ажиллуулах гэхээр яг тухайн салбарт мэргэшсэн гадаад, дотоодод боловсрол эзэмшсэн, тухайн салбарын ОУБ-д ажиллаж байсан залуучуудыг ингээд аваад ажиллуулъя гэхээр яг төрийн албанд ороод ажиллах гэхээр төрийн албаны шаардлагыг хангадаггүй юм. Тэгэхээр энэ үндэсний хороон дээр ажиллуулаад, төрийн бодлого, шийдвэрт оролцуулах, зарим хууль тогтоомж боловсруулахад оролцуулаад явж байгаа. Үндэсний хорооны гол зорилго юу вэ гэхээр тухайн асуудлыг шийдвэрлээд татан буугдах. Ийм л эрх зүйн орчинтой. Тэгэхээр асуудлаа шийдвэрлээд, татан буугдана гэсэн үг. Тэрнээс биш нөгөө үргэлж оршин тогтноод.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Мэндсайхан сайд, үгүй ээ зарим хорооны цалингийн сан яамны цалингийн сантайгаа тэнцүү байгаа шүү дээ. Би нэрийг нь хэлээд яах вэ.

З.Мэндсайхан: Учрал сайдаа ажлын албатай 14 үндэсний хороо байна гэж байна л даа. Тэгээд энэ чинь өөрөө асуудал байхгүй юу. Миний асуугаад байгаа юм нэг ийм юм байгаа юм. Жишээ нь Доржханд сайд энд Шадар сайд сууж байна. Монгол Улсын эрчим хүчний салбарыг Чойжилсүрэн гэдэг сайд удирдаж байгаа. Энэ намаржингаа эрчим хүчний реформ гэж ярилаа. Үнэ тариф нэмээд, өнөөдрийг хүртэл чимээгүй болсон. Энэ үнэ тариф нэмэх асуудлыг чинь Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв 2 тооцоолоод гаргаад ирчихсэн юм. Тэгээд энийг энэ хийдэг мэргэжлийн байгууллага нь байж байна. Тэгээд яагаад энэ дээр Эрчим хүчний хороо гэж байгуулаад, үгүй ээ тэр сайд нь тэр зохицуулах хороо эд нар ажлаа хийж чадахаа байчихсан юм уу? Ийм л юман дээр би асуулт асуугаад байгаа юм, хариулт хүсээд байгаа юм.

Ц.Даваасүрэн: Доржханд сайд.

Т.Доржханд: Баярлалаа. Мэндсайхан гишүүнд талархлаа илэрхийлье. Энэ асуултыг асуусанд. Энэ дээр яг бодитой мэдээллийг өгөх нь зүйтэй байх. Ер нь зарчмын хувьд нөгөө давхардсан функц байх юм бол тэрийг арилгаад явах нь зүйтэй л дээ. Гэхдээ нөгөө Засгийн газрын хүчин чадал гэж байна, хүрэх зүйл гэж байна, хийж чадахгүй зүйл гэж байна. Эрчим хүчний реформ гэдэг бол үнэ тарифын өсөлт зөвхөн тарифын өөрчлөлт биш юм гэдгийг бид маш олон удаа хэлсэн. 34 жилийн хугацаанд хэрвээ энэ ингээд салбар хөгжөөд явах байсан бол хөгжөөд л явах байсан. Болохгүй л байсан байхгүй юу. Тэгээд өнөөдөр нийт эрчим хүчнийхээ 22 хувийг гаднаас импортолж байгаа. Үнэ тарифын өөрчлөлт битгий хэл, реформ битгий хэл огт хөдлөөгүй өнөөдөр дутагдалтай явж байгаа нь бодит үнэн шүү дээ. Яах вэ сайн зүйл байгаа л байх. Гэхдээ үр дүн бол өнөөдөр ийм байгаа. Эрчим хүчний реформ гэдэг нь юу хийх гээд байна вэ.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Доржханд сайдын микрофоныг нэмээд өгчихье.

Т.Доржханд: Дутагдлаас бид экспорт руу чиглэе, хүрнээс ногоон руу чиглэе, тэгээд технологийн дэвшил хийе гээд ингээд маш олон зорилтууд тавиад явж байгаа. Бүтцийн өөрчлөлт хийнэ. Бид 8 арга хэмжээг зохион байгуулаад, тэгээд бэлтгэл ажлаа хангаад явж байгаа 1.

2 дугаарт нөгөө томоохон хэмжээний төслийг санхүүжүүлье гээд тэгэхэд түүн дээр чинь асар их хэмжээний судалгаа хэрэгтэй байдаг. Бичиг цаас хэрэгтэй байдаг. Зөвхөн финансинг буюу бичиг баримт нь тухайлбал 500 хуудас байх байхгүй юу. Энийг чинь тухайлбал хийнэ гэх юм бол манай Эрчим хүчний яам дээр тийм нөөц байхгүй. Сангийн яаман дээр ч ховор шүү. Энийг чинь гаднын болон дотоод экспертизүүдийг авч, аутсорсинг хийж байгаад явах юм. Одоо бид тухайлбал Ерөнхий сайдтай цуг өмнөх долоо хоногт Саудын Араб болоод Эмиратаар яваад ирлээ. 15 гегаваттын хөрөнгө оруулалт хийе гээд ярьж байгаа юм. Тэр нь болохоороо aqua power гээд тэгээд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Одоо дэг зөрчигдөнө. Эрчим хүчний хүрээлэн гээд байна. Судалгаа хийх бүрэн хүчин чадалтай 70, 80 байгууллагатай, Хөгжлийн төв гээд бас 70, 80 байгууллагатай, Зохицуулах хороо гээд 70, 80 хүнтэй. Зохицуулах хороо бол хангалттай мөнгөтэй газар байхгүй юу. Энэ эрчим хүчний энэ дундын юунаас

тарифаар авч байгаа. Диспетчерийн төв байна. Тэгэхээр хангалттай бий. Тэд нар зөвлөх аваад ажиллуулбал бүрэн чадна. Тийм учраас энэ дээр тийм тайлбар зохисгүй байх. Яагаад гэвэл Эрчим хүчний үндэсний хүрээлэн нь өөрөө байж байна шүү дээ. Тэр судалгааг нь хийгээд явж байх ёстой. Үгүй ээ тэгээд та нарын үр дүн сайн болно гэдгийг хэн батлаад байгаа юм бэ? Жишээлбэл 17 онд бид яг эрчим хүчний ингээд дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө гэж баталсан байгаа. Хэрэгжүүлээгүй шүү дээ, нэгийг нь ч хэрэгжүүлээгүй шүү дээ. Тэгэхээр наадах чинь бол зүгээр ярих нэг өөр, гүйцэтгэл шал өөр байгаад байгаа байхгүй юу. Учрал сайд, нэмэлт 1 минут.

Н.Учрал: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хууль дээр өөрчлөлт оруулаад бид хамтдаа Хяналт үнэлгээний үндэсний хороо, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, 20 минутын Үндэсний хороог байгуулаад эрхэлсэн ийм сайдтай болсон. Тэгэхээр энэ 3 үндэсний хороо бол ажлын албатай байх нь зайлшгүй шаардлагатай байгаа. Энэ чинь нөгөө яамгүй сайдууд гэсэн үг. Тэгэхээр энэ 3 хороо дээр л 15 хүн ажиллаж байгаа. Алсын хараа 2050 30 гаруй хороодыг нийлүүлээд 1 хороо болгоод Ерөнхий сайд ахалдаг. Энэ юу вэ гэхээр салбарын яамнуудын хооронд нь нөгөө бодлогын баримт бичгүүд дээр нь уялдааг нь хангаж ажиллаж байгаа ийм хороо. Олон жил явж ирсэн Эдийн засгийн зөвлөл бол жишээ нь 5 хүн ажилладаг. Үүн дээр нэмэгдээд Баялгийн сан, Эрчим хүч, Шинэ хоршоо гэсэн 3 үндэсний хороо байгаа. Энэ 3 үндэсний хороо бол ажлын албатай гэсэн үг. Тэгээд ер нь бусад Үндэсний хороо, комисс, зөвлөл бол ямар нэгэн ажлын алба байхгүй.

Ц.Даваасүрэн: Гишүүдээ сууж бай, суучихъя. Хэдүүлээ нэг хуралдааныхаа товыг ярилцаадахъя. Байнгын хорооны хуралдааныг маргааш 8 цагаас эхлэхээр яг энэ ирцээрээ шүү, үргэлжилж байгаа шүү. Байнгын хорооны хуралдаан үргэлжилж байгаа, хаагаагүй. Тэгээд хадгалчих. 8 цагаас, гишүүдээ харин 8 цагтаа яг эхэлнэ шүү. 8 цагтаа эхлэхгүй бол болохгүй шүү.

Хуралдаан 21 цаг 04 минутаас түр завсарлав.

Хуралдаан 2024.12.11-ний өдрийн 08 цаг 24 минутаас үргэлжлэв.

Ц.Даваасүрэн: Саяын бүртгүүлчихсэн байгаа гишүүдээ манай Тамгын газрын ажлын хэсгийнхэн дуудчих. Тэгээд ингээд санал хураалтаа эхэлье. Ажлын хэсэг энэ тэр орёе, цөөхөн юм байна лээ, гайгүй. Ажлын хэсгийн дарга Тэмүүлэн ажлын хэсгийнхээ танилцуулгыг хийнэ. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье. Хуралдаан үргэлжилж байгаа, өчигдөр нээлттэй орхисон. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2024

оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 303 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүн миний бие ахлан, Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Сэддорж, Алдаржавхлан, Ариунзаяа, Аубакир, Батжаргал, Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Баярмаа, Ганмаа, Ганхуяг, Жаргалан, Жаргалсайхан, Заяабал, Мандхай, Мөнхбат, Мөнхтулга, Нарантуяа-Нара, Номинчимэг, Пүрэвдаваа, Соронзонболд, Түвшин, Уянгахишиг, Цэнгүүн, Энхбаяр, Энхтүвшин нарын 26 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 2024 оны 12 дугаар сарын 7, 8, 9, 10-ны өдрүүдэд тус тус хуралдлаа. Ажлын хэсэг хөрөнгө оруулалт, урсгал зардал, Засгийн газрын тусгай сан төрийн өмчит аж ахуйн нэгж, гадаад зээл, тусламж болон төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийг нягтлах судлах 6 дэд ажлын хэсэгт хуваагдан ажиллаж, Дэд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус бүр сонсож, тодорхой зарчмуудыг баримтлан асуудлыг хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэсэн дараах саналуудыг та бүхэнд танилцуулж байна.

1.Хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулан дараах зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна. Үүнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилт хэсэгт туссан бүтээн байгуулалтын салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батлахаар, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд гаалийн татварын хөнгөлөлт эдлэх салбарт газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмж, мөн хөнгөлөлт эдлэх боловсруулах үйлдвэрийг тодорхой болгох үүднээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу баталсан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, түүний тодорхойлолтыг баримтлахаар тусгалаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн зүйл буюу 21¹.12 дахь хэсгээс аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтоохоор заасан байсныг хасахаар, 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдааны үр дүнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах болсонтой холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаахаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд хуулийн дагаж мөрдөх хугацааг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болгож өөрчлөхөөр саналуудыг гаргаж байна.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хувьд төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр арга хэмжээг авах, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж, зардлын эдийн засгийн ангиллыг төсвийн ерөнхийлөн захирагч зориулалт, арга хэмжээний нэр, төрлөөр цаашид жилийн төсвийн тухай хуулийн хавсралт болгон нэмэлтээр тусгаж байх, олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн

байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги, төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг санал гаргалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухайд бүх шатын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар төсөвт багтаан шийдвэрлэх, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, тусгай сан тус бүрийн төсөвлөлт, зарцуулалт, зориулалтын асуудлаар гүйцэтгэлийн аудит эсхүл олон улсын итгэмжлэгдсэн аудитын байгууллагаар аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах. Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэх, хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны 2 дугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийх. Төрийн байгууллагад ашиглаж буй мэдээллийн систем, программ хангамж, тоног, төхөөрөмж, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног, төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, тайланг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах зэрэг үүргийг Засгийн газарт өгөхөөр санал бэлтгэсэн болно.

2.Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны талаар. Засгийн газрын тусгай сангийн хуулиар нийт 27 санг нэрлэн заасан бөгөөд үүнээс 13 сан нь тухайлсан хуулиар үйл ажиллагааг нь нарийвчлан зохицуулсан байна. Бусад 14 сангийн холбогдох харилцааг Засгийн газрын тусгай сангийн хуулиар зохицуулж байгаа бөгөөд сангийн эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламж, тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн хүүгийн орлогоос бүрдэж байна. 2025 оны төсвийн төсөлд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгаагүй зарим сангуудад санхүүжилт төлөвлөсөн байна. Өнгөрсөн онуудад зарим тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн, хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан, зарцуулсан асуудлаар Үндэсний аудитын тайланд тусгагдаж, хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

Иймд төсвийн төсөл болон дагалдах хуулийн тогтоолд Засгийн газрын тусгай сантай холбоотой дараах саналыг танилцуулж байна. Үүнд, Боловсролын зээлийн сангийн хуримтлагдсан авлагыг 33,6 тэрбум төгрөгөөр эргэн төлөлтийг нэмэгдүүлэх, Боловсролын зээлийн сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр тус сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хуримтлагдсан авлагын эргэн төлөлтийг 40,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зардлыг 6,9 тэрбум төгрөгөөр, Байгаль орчин, уур амьсгалын сангийн зардлыг 0,7 тэрбум төгрөгөөр тус тус хасах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн дээрх сангуудад улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй болгосон санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэх замаар төсвөөс санхүүжих дүнг бууруулах, нөгөө

талдаа тус сангуудын зарцуулалтын нийт зардлыг нэмэгдүүлэхгүйгээр үр ашигтай захиран зарцуулж, зохицуулалт хийх саналыг гаргасан болно.

3.Төрийн өмчит ААН-үүдийн үйл ажиллагааны талаар. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага 2,7 их наяд төгрөгт хүрснээс 92,7 хувийг төрийн өмчит, 7,3 хувийг орон нутгийн өмчит ААН-үүдийн авлага эзэлж байна. 2023 онд төрийн өмчит 75 хуулийн этгээд 5,2 их наяд төгрөгийн ашигтай ашигтай, 62 хуулийн этгээд 508,5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаатай холбоотой дараах саналыг гаргаж байна. Үүнд, Монгол Улсын 2025 оны төсөв батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийг тодорхой хугацаанд Улсын Их Хуралд өргөн барих асуудлыг Засгийн газарт даалгах, төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага 2023 оны эцсийн үлдэгдлээр 2,7 их наяд төгрөг байгааг бууруулах арга хэмжээ авах. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хооронд зээл олгож байгаа үйлчилгээг таслан зогсоох, үүссэн өр авлагын асуудлыг цэгцлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх. Төрийн болон орон нутгийн өмчит ААН-үүдийн үйл ажиллагааг сайжруулж, хуримтлагдсан өр авлагыг барагдуулснаар тус ААН-үүдийн мөнгөн хөрөнгө сайжирна. Нөгөөтээгүүр мөнгөн хөрөнгийн эх үүсвэр сайжирснаар авах зээлийн хэмжээ буурч, зээлийн хүүгийн зардал бууран ашиг нэмэгдэнэ. Төсөвт төвлөрүүлэх ноогдол ашгийн хэмжээ өсөх, улсын төсвөөс авах дэмжлэг, татаас буурах давуу талтай гэж үзсэн болно.

4.Гадаад зээл, тусламжийн санхүүжилтийн талаар анхаарах асуудал. Гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа 70 төслийн ашиглаагүй зээлийн дүн нь 10,5 их наяд төгрөгт хүрч, үүнээс үүдэн шинэ төсөл нэмэх орон зай байхгүй болох нь эргээд төслийн үргэлжлэх хугацааг уртасгах, үр ашиггүй байдал руу орох үндэс болж байна. Иймд төслийн ашиглалтыг сайжруулах зайлшгүй хэрэгцээтэй төслүүдийг хэрэгжүүлэх нь чухал байна. Шинээр зээлийн гэрээ хэлэлцээр байгуулахдаа эдийн засгийн үр ашигтай төслүүдийг тодорхой шалгуурын үндсэн дээр сонгон хэрэгжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх хэрэгтэй. Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар гадаад зээлийн ашиглах, үнэлэхтэй холбоотой журмыг батлан мөрдүүлж байна. Энэ журам нь салбарын яамнууд сонгож санал болгосон тодорхой төсөл зээлийг үнэлэх журам юм. Харин уг төслийг зөвхөн зээлээр бус өөр хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлэх боломжтой эсэхэд харьцуулсан судалгаа хийгддэггүй байна.

Гадаад зээл, тусламжийн ашиглалтын талаарх дараах саналыг тогтоолын төсөлд нэмэх. Үүнд, гадаад зээл ашиглалтыг үр ашигт тулгуурласан, эдийн засгийг тэлэх томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шалгуураар эрэмбэлж, удаашралтай, үр ашиг багатай төслүүдэд зохих арга хэмжээ авч танилцуулах. Цаашид зээлийн гэрээг үр ашигтай байх зарчмыг баримталж, зээлийн бүрэлдэхүүнд урсгал зардал буюу зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал, сургалт гэх мэт урсгал зардлын эзлэх хувь хэмжээг бууруулах. Цаашид хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой төслүүдийг гадаад зээлээр санхүүжүүлэхгүй байх арга хэмжээг авах.

5.Урсгал зардлын талаар анхаарах асуудал. Зарим төрийн байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдсэн шинэ орон тоог 2024 оны түвшинд байхаар бууруулж, холбогдон гарах цалингийн сан, НДШ болон холбогдох бусад үйл

ажиллагааны зардлыг төсвийн төслөөс бууруулах нь зүйтэй гэж үзлээ. Засгийн газрын тухай хуулиар Засгийн газрын гишүүдийн эрхлэх үндсэн хүрээний ажлыг хуулиар тодорхой тусгаж, зохицуулсан байдаг. Төрийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах зорилгоор Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын чиг үүргийн давхардлыг арилгаж, Төсвийн тухай хуульд зааснаар хамгийн бага зардлаар, хамгийн өндөр үр өгөөж өгөх шалгуур үзүүлэлт, үр дүнг цаашид Улсын Их Хурал шаардаж байх болно. Иймээс төрийн албаны бүтэц, орон тоо, чиг үүрэг, давхардал, хийдэл, тухайн ажлын үр дүн, хэмжих шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тооцож, хамгийн оновчтой бүтэц, бүрэлдэхүүн, шийдлийг эрэлхийлж, төсвийн төслийг боловсруулж байх нь зүйтэй гэж үзсэн болно.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн талаарх эрх зүйн орчин хангалтгүй, Сангийн сайдын зардлын эдийн засгийн ангилал баталсан тушаал хэт ерөнхий, мөрдөх боломжгүй байгааг засаж залруулах нь зүйтэй гэж үзлээ. 2025 оны төсвийн жилд зарим төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарим урсгал зардлыг бууруулах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал ХХААХҮ-ийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3 тэрбум төгрөгөөр, Эрчим хүчний реформын үндэсний хорооны мэдээ сурталчилгааны зардлыг 9 тэрбум төгрөгөөр, бүх төсөвт байгууллагын түлш, халаалтын зардлыг 11,5 тэрбум төгрөгөөр, ЗГХЭГ-ын даргын төсвийн багцад тусгагдсан төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулах саналыг Ажлын хэсгээс дэмжсэн болно.

Зардал нэмэгдүүлэх. 6.Зардал нэмэгдүүлэх. 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх нийгэмд тулгамдсан зарим асуудлыг санхүүжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд хавдрын эмнэлгийн барилгын лизингийн төлбөрт 20 тэрбум төгрөг, тус эмнэлгийн шинэ тоног, төхөөрөмжийн зардлыг найм аравны, 8 тэрбум 881,7 сая төгрөгөөр, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж 31,4 тэрбум төгрөг, цэцэрлэг болон 3 ээлжээр хичээллэж байгаа ЕБС-ийн байрны түрээсийн зардалд зориулж 10 тэрбум төгрөг, Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засварын 2025 онд санхүүжих дүн 2 тэрбум 881,4 сая төгрөгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад нэмж тусгахаар шийдвэрлэлээ.

Улсын Их Хурал, Байнгын хороо, ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүд болон ТББ-аас албан бичгээр ирүүлсэн санал бүрийг судалж, эдгээр саналуудыг хуралдаанаараа нэг бүрчлэн хэлэлцсэн болно. Ажлын хэсгээс шийдвэрлэсэн дээрх асуудал холбогдох тооцоотой холбоотой саналын томъёоллыг бэлтгэж та бүхэнд хүргүүлж байна. Эрхэм Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, ажлын хэсгийн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэмүүлэн гишүүнд баярлалаа. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулна. Санал хураалт явуулахын өмнө хэдүүлээ ирцийн санал хураалт нэг явуулаадахъя. Ирцийн санал хураалт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал.

1.Урсгал зардал бууруулах санал.

1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдсэн шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,484.1 сая төгрөгөөр;

-Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг 7,738.1 сая төгрөгөөр;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,901.9 сая төгрөгөөр;

-Дотоодын цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,899.9 сая төгрөгөөр;

-Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,720.5 сая төгрөгөөр;

-Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,238.1 сая төгрөгөөр;

-Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,603.5 сая төгрөгөөр;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг 8,250.1 сая төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг 948.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 650.0 сая төгрөгөөр, нийт 9,848.9 сая төгрөгөөр;

-Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,095.2 сая төгрөгөөр;

МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг 82.9 сая төгрөгөөр;

Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,142.3 сая төгрөгөөр;

-Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг 309.4 сая төгрөгөөр, нийт 40,064.7 сая төгрөгөөр бууруулах. Байж байгаарай. Энийг чинь бүр ингээд нийтэд нь унших юм байна.

1.2. Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3,000.0 сая төгрөгөөр;

-“Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

-Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг 11,500.0 сая төгрөгөөр;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр бууруулах.

1.3. Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг 9 тэрбум, 6,900.0 сая төгрөгөөр бууруулах;

-Байгаль орчин, уур амьсгалын сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг 698.5 сая төгрөгөөр бууруулах.

2. Зардал нэмэгдүүлэх санал.

2.1. Хавдрын эмнэлгийн барилгын 2025 оны төсвийн жилийн лизингийн төлбөрт 20,000.0 сая төгрөг, тус эмнэлгийн тоног, төхөөрөмжийн зардалд 8,881.7 сая төгрөг, нийт 28,881.7 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж 31,400.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3. Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж 10,000.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4. Төслийн 2 дугаар хавсралтын ХХII.2.3. Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,881.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Ж.Золжаргал, Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, М.Мандхай, Ц.Мөнхбат, Б.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Б.Түвшин, Г.Уянгахишиг, Ц.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэх. Саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ саналыг хүчингүй болгочихъё. Энэ саналыг хүчингүй болголоо. 1 л санал юм байна. Тэмүүлэн гишүүнд тайлбар

өгчихье. Ажлын хэсгийн л тайлбар өгнө. Тэрнээс биш нөгөө өөр гишүүдээс юу байхгүй юм байна дэгээрээ. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүд та бүхэнд товчхон би тайлбар өгье гэж бодож байна. Тэгээд яах вэ энэ удаагийн Төсвийн ажлын хэсгийн зүгээс сая өнгөрсөн энэ 4 хоногийн хугацаанд ерөнхийдөө нэлээн ачаалалтай, богино хугацаанд л ингээд ажиллалаа. Та нар маань нэг талдаа манай ажлын хэсгээс оруулж байгаа саналыг зарчмын хувьд дэмжиж юу яагаач л гэдэг саналыг 1 дүгээрт хэлэх байгаад байгаа юм. Үндсэндээ энэ төсвийн зарлагын хүрээнд бид бүхний нэг талдаа хэмнэлт хийж болох гэдэг юм уу, 1 удаагийн төсөв, санхүү хүнд байгаа энэ цаг үе дээр тодорхой хэмжээнд алдагдалгүй төсөв батлах хүрээнд урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах, зарим чиг үүргийн давхардлыг арилгах, зардлыг бууруулах энэ бодлогыг баримталж ажилласан.

Би сая манай гишүүд маань та бүхэн анхаараарай. Ерөнхийдөө бид бүхний хувьд гол анхаарсан энэ удаагийн төсвийн зарлагын өсөлтийг нэмэгдүүлж байгаа гол үндсэн асуудал маань цалингийн зардалтай холбоотой. Тэр дундаа ирэх жил шинэ орон тоо нэмэгдүүлж байгаатай холбоотой 2000 орчим төрийн албан хаагчдыг нэмэгдүүлж байгаа асуудлууд байгаа. Тэгэхээр бид энэ асуудлыг тодорхой хэмжээнд өчигдөр ажлын хэсгийн хуралдаанд ярьж байгаад мөн өнгөрсөн 3, 4 хоногийн хугацаанд тодорхой төсвийн ерөнхийлөн захирагч нарыг дуудаж уулзаж үзэж, үндэслэл суурь шалтгааныг нь сонссоны үндсэн дээр 50-аас 100 хувиар бууруулахаар болсон байгаад байгаа.

Би энэ дотроо онцлоод хэлэхэд ЗГХЭГ-ын нэмэгдүүлэх орон тоо байсан 23 хүнийг шаардлагагүй гэж үзэж 100 хувиар бууруулж байгаа. Харин Цагдаагийн ерөнхий газар болоод Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон дотоодын цэргийн байгууллагын орон тоог нь нэмэгдүүлэх асуудлыг 50 хувиар нэмэгдүүлэх гэдэг асуудлыг тавьж байгаа. Тэгэхээр нэг талдаа бид нэг энэ төсөв санхүү хүнд байгаа, хэмнэлт хийх зайлшгүй шаардлагатай энэ цаг үе дээр 50 хувиар зохицуулалт нэмэгдлийг хийгээд явах нь зүйтэй юм гэсэн ийм байр суурийг үзсэн. Харин ганцхан Дотоод хэргийн их сургуулийн 107 хүн нэмэх асуудлыг энэ жилдээ тэвчиж, дараа жилээс нэмэгдүүлэх гэдэг юм уу, тодорхой үндсэн суурь шалтгаан оруулж ирж, судлуул гэсэн үндсэн дээр 100 хувиар хэмнэх шалтгааныг тавьсан байгаа. Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад хамаарах гэх юм уу харьяаны энэ 4 байгууллагын 3 байгууллага нь 50 хувиар орон тоо нэмэгдээд, 50 хувь дээр нь бол тэд нар тодорхой цалин хөлс болоод энэ нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой энэ зардлуудыг хэмнэх боломж бололцоо үүснэ гэж харж байгаа.

Цаашдаа бусад нь 100 хувиар хэмнэгдэж байгаа газрууд бол Төрийн албаны зөвлөл бид 100 хувиар нэмэгдүүлэх энэ саналыг нь буцаая, дэмжээгүй. Мөн Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 29 хүн нэмэгдэх байсан асуудлыг хойшлуулсан байгаа. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосон шүүгч болон бусад ажил, албан хаагчдыг нэмэгдүүлэх асуудлыг 50 хувиар нэмэгдүүлэх, тэр дундаа энэ салбарт эрэлт хэрэгцээтэй байгаа энэ ажил мэргэжлээр нь энэ жилдээ 50 хувиар нэмэгдүүлэх үнэхээр бодит боломж бололцоо байна. Тэр дундаа байр орон сууц болон нэлээн хүндрэлтэй байгаа нөхцөл байдлыг нь харгалзаж үзэж хувьчилж үзэх нь зүйтэй юм гэсэн үндсэн дээр бол үзсэн. Ингээд 50 хувиар хэмнэлтийг эндээс гаргаж байгаа.

Сонгуулийн ерөнхий хороо болон МОНЦАМЭ, Улсын Их Хурлын Тамгын Тамгын газар, Шүүхийн сахилгын хороо зэрэг эдгээр байгууллагуудын нэмэгдүүлэх орон тоог нь 100 хувиар бууруулж, ингээд ямар нэг нэмэгдэл явахгүйгээр өмнөх 24 оныхоо түвшинд нь явах ёстой гэсэн ийм бодлогыг бид ажлын хэсгээс гаргаж байгаа. Тэгэхээр энэ саналыг та бүхэн маань тодорхой ойлгож, анхаарч үзэж шийдэх нь зөв байх.

Цаашид бусад бид тодорхой төсвийн ерөнхийлөгч захирагч дээрээс зарим зардлуудыг бууруулах болон зохицуулалт хийснийхээ үндсэн дээр энэ хавдрын эмнэлэгтэй холбоотой асуудлууд дээр 3 зардлыг тавьсан. Хүүхэдтэй холбоотой асуудлууд дээр 2 зардлыг.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Та бүгдэд санал хураах дэгтэй холбогдуулаад нэг тайлбар өгчихье. Арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулна гэж байгаа юм. Тийм учраас тэр хэмжээгээр зардал бууруулах гэсэн бол тэр хэмжээгээр зардал нэмэгдүүлэх саналыг хамтад нь хураах ёстой учраас хамтад нь хурааж байгаа юм байна. Саяын ажлын хэсгээс гаргасан саналыг, үг байхгүй юм байна. Үг байхгүй юм байна шүү дээ. Учрал сайд тайлбар хийе.

Н.Учрал: ЗГХЭГ-ын урсгал зардлыг 1,4 тэрбумаар бууруулах гээд байгаа юм. Энэ ЗГХЭГ дээр сууж байгаа төсөв чинь энэ 21 аймгийн өөрсдийнх нь ирүүлсэн нэг талаасаа хөрөнгө оруулалтын зардлууд байдаг. Хэрэг эрхлэх газар дээр Ерөнхий сайдын ажлын алба, Шадар сайдуудын ажлын алба, ингээд хуультай үндэсний хороо, зөвлөлүүдийн ажлын алба эдгээр цалингийн урсгал зардлууд энд багтаж байгаа шүү дээ. Тэрнээс биш ЗГХЭГ-ын даргын төсөв дээр байгаа энэ зардал чинь зөвхөн Хэрэг эрхлэх газрын ажилтнууд ерөөсөө биш байхгүй юу. Яагаад гэхээр бүх Шадар сайдуудын ажлын алба, Ерөнхий сайдын ажлын алба эд нар чинь бүгдээрээ нэгтгэгдээд Хэрэг эрхлэх газар сууж байгаа.

Тэгэхээр яг ямар 23 орон тоо бууруулаад байгаа юм бэ гэдгийг, энэ чинь зөвхөн нөгөө Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудал биш. Энэ чинь Шадар сайд болгон өөр өөрийн эрхлэх асуудалтай шүү дээ чиглэл чиглэлийн. Тэгэхээр яг аль Шадар сайдын орон тооноос хэдийг хасаж байгаа юм бэ? Яг Үндэсний аль хорооны ажлын албанаас яг хэдийг хасаж байгаа юм гээд. Өчигдөр би тодорхой тайлбар хэлсэн. Ерөнхий сайдын дэргэд байсан Үндэсний бараг 30 гаруй хороог нэгтгээд, Алсын хараа 2050 гэдэг Үндэсний нэг л хороо болсон, нэг л ажлын албатай. Тэгээд өчигдрийн тайлбар хийснээр нийтдээ 15 Үндэсний хороо хуультай хороод л ажлын албатай байгаагаас биш бусад тэр зөвлөлүүд, комиссууд, хороод чинь ямар нэгэн тийм урсгал зардал, ажлын алба гэдэг зүйл огт байхгүй.

Тийм учраас Хэрэг эрхлэх газрын даргын төсөв гээд яриад байдаг. Энэ чинь яг үнэндээ аймаг, орон нутгуудаас ирсэн саналууд, тэгээд цалингийнх нь зардлууд эндээ нэгтгэгдээд сууж байгаа учраас л ийм зардал байгаа харагдаад байгаа болохоос биш яг Хэрэг эрхлэх газрын ажилчдын цалин гэж бас огт ойлгож болохгүй. Тэгэхээр ажлын хэсгийн зүгээс бид нарт их ойлгомжтой тайлбарлаж өгөөч. Аль, ямар чиглэлийн эрхлэх асуудлыг хариуцаж байгаа Шадар сайдын ажлын албанаас хэдийг хассан юм бэ? Аль Үндэсний хорооноос хэдэн хүн хасаад байгаа юм бэ гээд хэлэхгүй бол ерөнхий байдлаар 23 орон тоо гээд ингээд

хасчихвал бид чинь хаанаасаа, ямар хүмүүсийг ажлаа хийж байгаа хүмүүсийг ажлаас нь чөлөөлөх вэ гэдэг чинь их том асуулт шүү. Тийм учраас тэрийг тодорхой хэлж өгөөч гэж хүсэх гээд байна.

Ц.Даваасүрэн: Тэмүүлэн гишүүнд 1 минут өгчихье. Энэ чинь дэг нь их хоёрдугаар хэлэлцүүлгийн дэг чинь их төвөгтэй юм байна шүү. Ерөөсөө зөвхөн Засгийн газар тайлбар гаргаж, сонсож болно гэхихсэн юм байна.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр манай гишүүд маань, сайд нар, Засгийн газрынхан маань ч гэсэн нэг зөвөөр ойлгоорой. Энэ дээр ерөөсөө одоо байгаа 25 онд байгаа бүтэц дээр бид ямар нэг таналт хийсэн зүйл бол биш орон тоо дээр. Харин зүгээр 25 онд шинээр нэмэгдэх гээд байгаа энэ орон тоонуудыг нэг талдаа нэг жилийн хугацаанд бид хэмнэлт хийж байгаа энэ цаг үеийн хүрээнд тэвчих нь боломжтой юм. Шинэ орон тоо нэмэх шаардлагагүй, орон тооны хэмнэлт хийх, чиг үүргийн давхардлыг арилгах чиглэлээр та бүхэн маань одоо байгаа бүтэц дотор ажиллаач гэдэг асуудлыг тавьж байгаа.

Тэгэхдээ энэ дээр Засгийн газар дээр бид, Засгийн газар дээр бид 100 хувь шинээр нэмэх гэж оруулж ирсэн орон тоог нь хэвээр нь хадгалъя гэдэг асуудал явж байгаа. Харин Цагдаагийн ерөнхий газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, дотоодын цэрэг болон Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбоотой, шүүгч нартай холбоотой асуудлууд дээр 50 хувиар нэмэгдүүлж байгаа. Нийт үндсэндээ 3, 4 мянган хүний төрийн албан хаагч нэмэгдлийн асуудлыг дундчилаад аваад үзвэл бид 50 хувиар нэмж байгаа, заримыг нь 50 хувиар ирэх онд нэмэгдүүл, заримыг нь одоо байгаа бүтэц тооныхоо хэмжээнд хадгалаад аваад яваач.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Учрал сайд тайлбарлая. Манай Тамгын газрынхнаас хуулийнхан байна уу? Хүрээд ир дээ.

Н.Учрал: Би ойлгож байна, хэмнэлт хийх нь зөв гэдгийг ойлгож байна. Тэгэхдээ хамтарсан Засгийн газар байгуулагдаад тэр тодотгол хийсэн. Тодотголын хүрээнд тэр үндэсний хороодыг нэгтгээд, багасгаад ингээд 1 Шадар сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулиар нэмэгдээд, ингээд 3 Шадар сайдтай болоод ажлын албууд нь дэргэд нь байгуулагдаад, тэгээд дээрээс нь зарим үндэсний хороод, жишээ нь тухайлбал тэр Шинэ хоршоо ч гэдэг юм уу энэ үндэсний хороо чинь эрхлэх асуудлын хүрээнд өөр Шадар сайд руу ирээд, төсвийн тодотголд суугаад ажлаа хийж байгаа. Гэтэл ирэх оны төсөв дээр шууд ингээд тоо тавиад хаслаа гэхээр чинь бид төрийн албан хаагчдаасаа аль, аль, хэн хэнийг нь 23-ыг ажлаас нь чөлөөлөх юм бэ?

Ц.Даваасүрэн: Засгийн газрын тайлбарыг сонсож болно гэж байгаа юм чинь Алтангэрэл сайдыг микрофоныг өгчихье. Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Надад асуулт байгаа юм. Тэгвэл тайлбар хэлчихье. 50 хувиар нэмэгдүүлсэн гэж яриад байна л даа. Хуулиараа хууль сахиулах байгууллагуудыг ийм, ийм үүрэг хий гээд Улсын Их Хурлаас хууль тогтоох дээд байгууллагаас хууль баталчихсан. Жишээлбэл энэ он гараад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдаагийн байгууллагаас

баривчлах байрыг шилжүүлж авна. Баривчлах байр, эрүүлжүүлэх 2 хамтдаа байдаг, орон тоо нэг гэсэн үг. Цагдаа дээр эрүүлжүүлэх нь үлдэнэ, шийдвэр гүйцэтгэл дээр баривчлах байр нь очно. Ингэхээр тэр баривчлах байр гэдэгт чинь харуул манаа, ээлжийн ахлах, офицер, эмч, сувилагч хэрэгтэй болдог юм. Тэгээд энэ чиг үүргээ яаж гүйцэтгэх вэ? Төрийн хуулиар хүлээсэн үүргээ энэ байгууллагууд яаж хийх юм бэ?

Хамгийн ойрын жишээ гэхэд Улаанбаатар хотод нийслэлээс санхүүжүүлж байсан 160 гэрээт орон тоог ирэх онд чадахгүй гээд хэлчихсэн. Та нар энэ зам дээрээ гарч замаа зохицуулах юм уу? Хотын зам зохицуулж байгаа 160 залууг хасах болж байна бид. Тэгээд 50 хувилж байна гээд 80-ыг нь зогсоогоод, 80-ыг нь хасах юм уу, тэртээ тэргүй хүрэхгүй байна. Хэмнэх гэж байгаа бол өөр юмнаасаа хэмнэе. Тэр гоё сайхан попорч хийсэн тэр зардлуудаасаа хас. Ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа, орон тоо нь дутаад байгаа, одоо 6000-аар дутаж байгаа, одоо 2000 гаруй дутаж байгаа. Энэ тус тусын байгууллага дээр нэмүүлэх гэсэн энэ нэг хандлагаас мөнгө авах гэж байгаа боль. Хэмнэх зөндөө мөнгө байна.

Аймгууд байгаа юм. Усны цэвэр хангамжийг нь хамгаалах гэж байгаа. Баян-Өлгий 42, Булган 46, Говьсүмбэр 50, Дундговь 54, Завхан 50, Сүхбаатар 58, Сэлэнгэ 46, Төв 50, Увс 54, Яармаг насос, Чингэлтэй насос, Хайлааст, Чингис хот, Мөрөн, Даланзадгад, Ховд энэ болгон ундны эх үүсвэр хамгаалах дотоодын цэргийн орон тоо. Одоо энэ ажлын хэсгийг хэлчих хэрэгтэй. Аль аймгийнхныг ялгаварлаад энэнээс нь хас гэж байгаа юм. Улаанбаатар хотынхон ундны цэвэр усаа дотоодын цэргээр хамгаалуулж болдог, хөдөөгийнхөн болохоор хөдөө амьдарч байгаа учраас болохгүй гэдэг ийм юм руу очиж байна. Аль чиг үүргээ энэ хууль сахиулах байгууллага, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэмэгдэж байгаа аль чиг үүргээ 50 хувь дутуу хийж болохыг нь тэгвэл хэлээд өг. Хуулиар үүрэг хүлээлгэчихсэн, шинээр ажил үүрэг гүйцэтгэ гэсэн энэ хуулиудаа тэгвэл хүчингүй болгоод өг.

Энэ өдөр тутмын үйл ажиллагаа сахиулж байгаа, тэгвэл бүгдээрээ санаачилга гаргая л даа. Энэ хууль сахиулагч дээр арай ядан нэмэгдэж байгаа энэ зардлыг хасаж байгаа бол бүгдээрээ цалин авахаа больё л доо. Гудамжиндаа зохицуулагчгүй болох гэж байгаа бол тэр хэмнэх гээд байгаа, гоё сайхан яриад байгаа юу гэлээ.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Энэ чинь ийм юм байна. Зөвхөн Засгийн газар тайлбар хийдэг юм байна. Тэгээд хэрвээ Засгийн газар тайлбар хийгээд, энэ ажлын хэсгийн гаргаж байгаа санал хууль зөрчсөн гэж үзвэл нэгдсэн Засгийн газар мэдэгдэл хийж болдог юм байна. Өөр ерөөсөө зохицуулалт байхгүй байгаа байхгүй юу. Тийм учраас би нөгөө сайд нараар үг хэлүүлээд байгаа юм. Зүгээр ажлын хэсэг харин хариу тайлбар хийж, тэгэхдээ зохицуулаагүй л юм байна. Тэгэхдээ нэгэнт тайлбарлаж байгаа учраас ажлын хэсэг тайлбарлахаас өөр арга байхгүй. Би цагдаагийн ажилчдыг болохоор өчигдөр яах вэ 30 хувийг нь сайд зөвшөөрсөн гэж, салбар зөвшөөрсөн гэж ойлгосон тийм ээ? Тэгэхээр ажлын хэсгээс 50 хувийг нь, 50 хувь болгоод өөрчиллөө гэж ингэж ойлгоод байгаа. Тийм биз дээ Тэмүүлэн гишүүнээ? Тэрийг зөвшөөрөхгүй байгаа юм байна тийм ээ? 50 хувилахыг нь зөвшөөрөхгүй байгаа юм байна шүү дээ. Амарсайхан сайд, Амарсайхан сайд тайлбар хийе. Засгийн газар тайлбар хийж болно.

С.Амарсайхан: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Мэдээж хэмнэлт хийх тал дээр бүгд л байр суурь нэг, санал нэг байгаа. Гэхдээ хэзээ, хаанаас, юунаас вэ гэдгээ хэдүүлээ маш сайн тооцохгүй бол нөгөө халдавч хар халзандаа гэдэг шиг ингээд бидний энэ ард иргэдийн амь нас, аюулгүй байдал, тэгээд энэ өдөр, шөнө амгалан тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж байгаа энэ цагдаа хууль сахиулах байгууллагын хэдэн албан хаагчдыг, энэ чинь хүн ам нэмэгдэж байгаа шүү дээ. Тэр хэрээрээ газар нутаг, энэ засаг захиргааны нэгжүүд нэмэгдэж байгаа. Тэр хэрээрээ энэ аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын тоо нэмэгдэж байгаа. Энэ чинь хүссэн, хүсээгүй эдийн засгийн тэлэлт, хүн амын өсөлтөө дагаад нэмэгдэж байдаг ийм орон тоо бол багш, эмч, цагдаа, онцгой, хууль сахиулах байгууллага гээд байдаг байхгүй юу. Тэгээд тийм хүмүүс рүүгээ бид ингээд байгаа хэдэн.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 7 номерын микрофоныг өгье Засгийн газар, Засгийн газрын тайлбарыг сонсьё.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Орон тоог Сангийн яаман дээр хянахдаа хамгийн зайлшгүй шаардлагатай гэсэн орон тоог бол хянасан. Цагдаагийн байгууллагын хувьд яг маргаан үүсгэхэд энэ асуудал дээр ямар асуудал байсан гэхээр 21 аймаг, 9 дүүрэг дунджаар 500 орчим хүн ажилладаг. Цагдаагийн байгууллага хэв журам сахиулах, гэмт хэрэг мөрдөх, соён гэгээрүүлэх гэх мэт чиг үүрэг байгаад байдаг. Жишээ нь аймгууд дээр жил болгон ер нь 20-оод орон тоо сул явдаг, 500-аас 20 гэсэн үг. Янз өөрийн шалтгаантай. Дүүргүүд дээр тэрнээс бүүр өндөр 50, 60 хүн сул явдаг юм байна лээ.

Бид өмнө нь яг ингэж сул явж байгаа орон тоонуудыг нь хасаж нэг үзсэн юм. Тэгэхээр юу болсон бэ гэхээр жишээ нь хүүхдийн асуудал хариуцсан байцаагч нарын орон тоо байхгүй болчихоор тухайн аймаг дүүрэгт нь гэмт хэрэг асар өсчихдөг юм байна лээ. Тийм учраас сул орон тоо ингээд энэ хэмнэгдлээ гэж үзээд байж болохгүй л юм байна лээ. Жишээ нь энэ бусад төсөвт байгууллагууд дээр бид үзсэн. Ойролцоогоор 7-гоос 8 хувийн бол.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Гишүүдээ саналаа хураая. Гишүүдээ анхаараарай. Саяын саналыг зардал бууруулах, зардал нэмэгдүүлэх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Батжаргал гишүүн. Батжаргал гишүүний микрофоныг өгье. 20-оос 8 дэмжээд 40 хувийн саналаар энэ санал уначих гээд байна, унаад байна. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Саяын санал хураалтын томьёоллыг дэмжиж санал өгсөн, хурууны хээ уншигдсангүйгээс санал өгөгдсөнгүй. Тийм учраас энэ саяын саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний гаргасан саналын томьёоллоор саяын энэ чинь хоёрхон л явуулна шүү. Үгүй ээ болохгүй, заавал санал хураалт явуулна. Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал хураалт гишүүдээ, Батжаргал гишүүний саяын саналыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Горимын санал, сая минийх ажилласангүй. Засгийн газрын төлөөлөл Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Ер нь яах вэ одоо наана чинь ингээд ажлын хэсэг саналаа боловсруулаад оруулж ирсэн. Санал хураалт явуулаад унаад, дахиад гуравдугаар

хэлэлцүүлэг рүү гэхээр энэ унжирч сунжраад бүр сонин байдал руу орох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо ажлын хэсэг түр завсарлага аваад, гишүүд, бусад Байнгын хорооныхонтойгоо, сайд нартайгаа саналаа солилцоод, энийгээ дахиж нэг эргэж харж, өөрчлөх асуудлууд байвал зөвшилцөж, өөрчлөөд оруулж ирээд, саналаа хураагаад явчих нь зөв байгаа. Тэгэхгүй бол наана чинь уначихна. Угаасаа унах нь тодорхой болж байна. Дахиад наадах чинь, тийм. Сая зүгээр Батжаргал гишүүн горимын санал гаргаад, саналыг хүчингүй болгож байгаа учраас дахиж, энийгээ түр зогсоогоод, завсарлага аваад, энэ асуудлаа ажлын хэсэг ярьчихмаар байгаа байхгүй юу. Харин тийм. Тэгэхээр одоо ингэж хүчингүй болгож байснаас ажлын хэсэг дахиад.

Ц.Даваасүрэн: Сайд болно. Одонтуяа сайд, Одонтуяа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуяа: Бүгдээрээ энэ болохгүй, тэр болохгүй гээд яах вэ, аль болохоор зөвшилцөөд дэгийнхээ дагуу явъя. Тэгэхээр би Амарсайхан даргын сайдын саналтай санал нэг байна. Саяын орж ирсэн саналыг бид сая харлаа. Тэгээд энэ чинь дэмжигдээгүй учраас одоо нэг уулзаад, сайд нартай уулзаад, бид зарим зүйлийг нь хасахад зөвшөөрч байгаа. Өчигдөр надтай манай эмэгтэй гишүүд уулзаад хүүхдийн мөнгөн дээр тэд дутаж байна гэхээр би зарим зардлуудаасаа нэлээн танаад, ингээд зөвшилцөөд тэр саналууд болж байна.

Гэтэл хэн, манай Алтангэрэл сайдын ч юм уу үнэхээр болохгүй ийм зүйлүүд байгаа учраас сая дэмжигдэхгүй байх шиг байна шүү дээ. Тэгэхээр энийгээ одоо яг энэ дээрээ дахиж нэг уулзаад, салбар дотроо зохицуулалт хийж болно шүү дээ. Нэг уулзаад, зөвшилцөөд явбал яасан юм бэ? Тэрнээс биш энэ их олон хоногийн хөдөлмөр, тэр нь ч болохгүй, энэ ч болохгүй гээд. Ер нь Их Хурал чинь зөвшилцөж явж байж үр дүнд хүрдэг шүү дээ.

Ц.Даваасүрэн: Тэгвэл байна шүү дээ хэдүүлээ ингэе. Одонтуяа сайдын гаргаж байгаа горимын саналаа хэдүүлээ дэмжээд, түр завсарлага авъя гэж байгаа юм байна тийм үү? Тэгээд дахиад ажлын хэсэг нэг ярьчаад ороод ир гээд байна шүү дээ тийм үү? Тэгвэл би хугацаа ерөөсөө 30 минутаар өгчихье, болж байна уу? 30 минутын дотор Одонтуяа сайдаа? Ажлын хэсэг яаж байна вэ Тэмүүлэн? 30 минутын хугацаанд та хэд нэг ахиад санал солилцох уу? 30 минут тэгэх үү? Тэгвэл Одонтуяа сайдын гаргасан горимын саналаар санал хураалт явуулчихъя. 30 минутын завсарлага авуулаад, Засгийн газартай дахиад ярилцаадахъя. Хурлаа түр завсарлуулаад, 30 минутын хугацаанд ажлын хэсэг, Засгийн газар дахиад саяын нөгөө зардал бууруулах, нэмэгдүүлэх санал дээрээ ярилцъя. 30 минутын дараа хуралдаанаа үргэлжлүүлэе.

Хуралдаан 09 цаг 26 минутаас 11 цаг 58 минутад түр завсарлав.

Байнгын хорооны гишүүд хуралдаа орж ирээд, одоо санал хураалтаа үргэлжлүүлэе. Байнгын хорооны гишүүдээ дуудчих. Саяын ирцээрээ. 2 цагаас чуулган хуралдах учраас 2-оос өмнө бид санал хураалтаа хийж дуусгах шаардлагатай байна.

Ажлын хэсгийн 11 санал, Байнгын хороодын 30 санал, Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны гишүүдээс гаргасан 10 санал байгаа юм байна. Ингээд нийтдээ бараг 50-иад зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулах юм

байна. Тэмүүлэн гишүүнийг дуудъя. Тэмүүлэн гишүүн ажлын хэсгийн саналыг тайлбарлах ёстой. Батжаргал гишүүнийг дуудъя. Энэ манайхан Батжаргал гишүүнээ дуудъя. Ялангуяа ажлын хэсэгт байсан гишүүд санал хураалтад оролцох шаардлагатай байна шүү. Тэмүүлэн, хуралдаанаа үргэлжлүүлье. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье. Тэмүүлэн гишүүнээ микрофон нээгдлээ. Тэмүүлэн гишүүний микрофоныг, Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Сая Байнгын хорооны хуралдаан дээр унасан зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх 1 дүгээр санал болох урсгал зардал бууруулах санал байгаад байгаа. Тэгээд энэ дээр сая Байнгын хорооны хуралдаан дээр унасан санал байгаад байгаа. Тэгэхээр санал гаргасан гишүүн зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татаж авч болно гэсэн ийм дэгийн заалт байгаад байгаа. Тэгээд энэ дагуу унасан саналаа татаж авч байна гэдгээ мэдэгдэж байна.

Ц.Даваасүрэн: Бусад ажлын хэсгийн гишүүд энэ саналыг хураалгаад дэмжүүлсэн үү?

Г.Тэмүүлэн: Тэгсэн, тийм.

Ц.Даваасүрэн: Бусад ажлын хэсгийн гишүүд энэ саналыг дэмжсэн байна. Энэ саналыг буцааж татлаа. Дараагийн санал хураалтаа явуулъя.

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Урсгал зардал бууруулах санал.

1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдэхээр тооцсон шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,484.1 сая төгрөгөөр;

-Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг 7,738.1 сая төгрөгөөр;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,901.9 сая төгрөгөөр;

-Дотоодын хэргийн дотоод цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг 5,899.9 сая төгрөгөөр;

-Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,720.5 сая төгрөгөөр;

-Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,238.1 сая төгрөгөөр;

-Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,603.5 сая төгрөгөөр;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг 8,250.1 сая төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг 948.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 650.0 сая төгрөгөөр, нийт 9,848.9 сая төгрөгөөр;

-Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг 1,095.2 сая төгрөгөөр;

-МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг 82.9 сая төгрөгөөр;

-Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг 2,142.3 сая төгрөгөөр;

-Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг 309.4 сая төгрөгөөр, нийт 40,064.7 сая төгрөгөөр бууруулах.

1.2.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3,000.0 сая төгрөгөөр;

-“Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг 9,000.0 сая төгрөгөөр;

-Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг 11,500.0 сая төгрөгөөр;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах.

1.3.Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг 9,900.0 сая төгрөгөөр бууруулах; Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн, тийм 6,900.0 сая төгрөгөөр.

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг 698.5 сая төгрөгөөр тус тус бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал.

2.1.Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах эхний удаагийн төлбөрт 17,000.0 сая төгрөг, тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардалд 6,881.7 сая төгрөг, нийт 23,881.7 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж 31,400.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3.Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж 10,000.0 сая төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын ХХII.2.3.Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,881.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.5.Эрчим хүчний гэж бичээрэй, эрчим хүчний бодлогын шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх сайдын төсвийн багцад 5,000.0 сая төгрөг нэмж тусгах. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Золжаргал, Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, М.Мандхай, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин цаашид ажлын хэсэг. Энэ саналыг, ажлын хэсгээс гаргасан энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар дэмжигдсэн байна. Батжаргал гишүүн, чинийх бас уу, Батбаяр гишүүн, Цогтбаатар гишүүн нар дэмжсэн санал өгсөн байна. Протоколд авъя.

Дараагийн санал. Засгийн газрын тусгай сангийн нийт зардлыг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Боловсролын зээлийн сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 33,604.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, тус сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж 72,7 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Дараагийн санал. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 40,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, тус сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн саналын томьёолоор, дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар уг санал дэмжигдсэн байна. Энэ санал дээр байна шүү найруулгын чанартай сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр зардлыг зээлийн эргэн төлөлт

төвлөрүүлсэн гэсэн энэ найруулгыг жоохон эргэж харах шаардлагатай юм байна шүү. Энийг анхаараарай.

Дараагийн санал. Гурав.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

1.Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.2.1.Батлан хамгаалах салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 27,975.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 5,938.2 сая төгрөгөөр бууруулж, Батлан хамгаалах салбарын тоног төхөөрөмжийн зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 81,8 хувиар уг санал дэмжигдсэн байна.

2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Ойжуулалт хөтөлбөрийн зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, мөн сайдын их засварын зардлыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 19 гишүүн дэмжиж, 86,4 хувиар уг санал дэмжигдсэн байна. Тэр ойн хөтөлбөрийн зардлыг гэж найруулна шүү.

3.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.52.Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 46,659.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,909.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.22.Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 3,599.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,257.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 77,3 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

4.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,940.2 сая төгрөгөөр, XVI.1.1.5.Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 41,089.4 сая төгрөг, санхүүжих дүн 16,435.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, энэ эх үүсвэрээр “Хушаат сумын улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын дуусгал /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 13,880.4 сая төгрөг, санхүүжих дүн 6,640.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 19 гишүүн дэмжиж, 86,4 хувиар уг санал дэмжигдсэн байна. Тэр санхүүжих дүн нь 6,940.2 сая төгрөг юм байна шүү.

5.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.130.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 4,800.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг

гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 5,969.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 19 гишүүн дэмжиж, 86,4 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Дөрөв.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:

1.Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.3.2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн, үгүй ээ үгүй энэ чинь дэг зөрчихгүй, тайлбар байхгүй. Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.3.2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 165.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн академийн тоног төхөөрөмж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 19 гишүүн дэмжиж, 86,4 хувиар уг санал дэмжигдсэн байна. Түрүүний тэр нөгөө 5 дахь санал дээр тэр хэрэгжих хугацаа 25-аас 26 гэснийг 24 он шүү дээ гээд байна. Тэрийг нягтлаад эргэж тус эргэж тусгая.

Тав.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн. 1.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг 1,556.7 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 20 гишүүн дэмжиж, 90,9 хувиар энэ санал дэмжигдлээ.

6.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. 1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг 694.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж 68,2 хувиар энэ санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн санал хураалт дууслаа.

Одоо бусад Байнгын хороодоос ирүүлсэн санал хураалтыг эхлүүлье. Үгүй ээ үгүй, эхлээд санал хураалтаа төсвөө дуусгана шүү дээ. Дараагийн санал хураалтыг явуулъя. Бусад Байнгын хороодоос гаргасан санал хураалтуудыг явуулна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар бусад Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтийн 22.6.2.4.“Байгальд ээлтэй, дэвшилтэт техник,

технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж, хэмжих нэгжийг “тоо” гэж, Суурь оныг “2023” гэж, Суурь түвшнийг “0” гэж, Зорилтот түвшнийг “1” гэсэн арга хэмжээ нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. БОХХАА-н байнгын хороо дэмжсэн санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

2 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 2 дугаар хавсралтын “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Дархан-Уул, Хонгор сум/” гэснийг “Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Дархан-Уул, Хонгор сум/” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан. БОХХАА-н байнгын хороо дэмжсэн санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Авсан нь дээрээ. Энэ дээр Сангийн яам ямар саналтай байгаа юм бэ? Санал байна уу? Сангийн яамаа ингээд хураалгавал болж байна уу? Сангийн яам энэ дээр ямар саналтай байгаа юм бэ, болж байгаа юм уу? Жавхлан, хэн хариулах юм бэ? Энхбаяр сайд хариулах юм уу? Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Гишүүдийнхээ амгаланг айлтгая. Энэ дээр нэг нэрний давхцал үүсээд байгаа юм. Нэг төсөл нь хувийн хөрөнгө оруулалттай нэг төсөл, нөгөөдөх нь засгийн хөрөнгө оруулалттай төсөл. Нэрний ялгаанууд. Дархан арьс ширний цогцолбор гэдэг хувийн нэр дээр Дархан архи ширний цогцолборын дэд бүтэц гэдэг төрийн компани гарчихсан. Хувийн компанид гомдол гаргаад, нэр давхцаж байна гэсэн гомдол гаргаад төрийн компаниа шүүхэд өгчихсөн. Энэтэй холбоотойгоор төсөв дээр ийм маргаантай байдлаар хувийн хөрөнгө оруулалт руу энэ улсын төсөв орох ийм эрсдэл үүсэх, маргаан үүсэх ийм байдал үүсэж байгаа тул бид энэ Хөгжлийн бодлогод туссаны дагуу төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрийн аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц гэдэг дээр нь ерөнхий том зургаар нь оруулаад явах нь зүйтэй гэж бодож байгаа. Тэгэхээр энэ ерөнхий.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Болж байгаа юм байна тийм ээ?

Ж.Энхбаяр: Тийм тэгээд зорилго чиглэл өөрчлөгдөхгүй. Нэрийг нь өөрчлөх нь зүйтэй гэж.

Ц.Даваасүрэн: Гэсэн саналын томъёоллоор, Жавхлан гишүүн нэмээд хэлчихье. Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Энхбаяр сайдаа гишүүд ингээд байна л даа. Тэр нэр сольж байгаа шалтгаан нь бол Энхбаярын сайдын хэлээд байгааг ойлголоо. Ойлгож байгаа, ойлгоод байна. Зүгээр гагцхүү төвийн бүсийн зориулалттай ийм үйлдвэр юм уу, Монгол Улсын зориулалттай ийм үйлдвэр юм уу 1-д.

2-т ингээд төвийн бүсийн гээд тодорхойлоод тодорхой оруулчихаар дараа нь тэгээд бүс бүр дээр энийг хийнэ гэсэн үг үү гээд тийм нэг иймэрхүү асуудал үүснэ. Тийм. Тэгэхээр энийгээ аягүй зөв тайлбарлах хэрэгтэй юм байна лээ шүү. Тийм. Тэгээд энийгээ нэмээд тайлбарлаж байгаа юм. Яг төвийн бүсэд зориулсан арьс ширний цогцолборын үйлдвэр юм уу эсвэл яг Монгол Улсад зориулсан уу.

Бүс бүсэд нь дараа нь яах юу болох вий. Нэг ийм зүйл болох вий. Ойлгомжгүй байдал үүсчих вий.

Ц.Даваасүрэн: Энийг дараагийн санал хураалтын юун дээр анхааръя хэдүүлээ тийм ээ. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 36,4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 22.6.1.1 дэх заалтыг “Монгол Улсын бүх хот суурин буюу хүн ам төвлөрсөн газруудад озон, PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэмжих” гэж, суурь оныг “2023” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. БОХХАА-н байнгын хороо дэмжээгүй санал байна. Энэ дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор, гишүүний саналаар гэдэг чинь юу гэсэн үг вэ? Гишүүний саналаар нь дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 3 гишүүн дэмжиж, 13,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

4 дэх санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 22.6.1.2. дахь дэд заалтыг “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдэд агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. БОХХАА-н байнгын хороо дэмжээгүй санал. Гишүүний саналаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, 13,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

5 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтэд “30.8.1.2.Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь” гэж, хэмжих нэгжийг “хувь” гэж, суурь оныг “-” гэж, Суурь түвшинг “-” гэж, Зорилтот түвшинг “10” гэсэн арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Хүнс, хөдөө, БОХХАА-н байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 9,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал 6 дахь санал болохоор яах вэ эхлээд 6-г хийе. 6, энэ нөгөө нэг цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 31,4 тэрбум гэдэг. Энэ нөгөө хураалгачихсан санал учраас татаад авчих уу? Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгчихье. 6, 7-г хамтад нь татчих, 7 тийм санал юм байна шүү. Байгаль орчин дээр хураалгасан юм байна, Боловсрол, соёл дээр хураалгасан юм байна тэр 31,4-ийг.

Д.Үүрийнтуяа: Ажлын хэсгийн гишүүддээ мөн Байнгын хорооны гишүүддээ маш их баярлалаа. Хүүхдийн төлөө зарцуулах ёстой энэ хоолны зардлын 31,4 тэрбум төгрөг дэмжигдсэн учраас дараагийн 2 санал Боловсролын байнгын хороо болон Байгаль орчны байнгын хороон дээр хураагдсан саналуудаа татъя, татаад авъя.

Ц.Даваасүрэн: Ингээд Үүрийнтуяа гишүүн 6, 7 дахь цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал худалдан авах зардал 31,4 тэрбум хураагдсан учраас татаж авч байна. 8 дахь санал. Улаанбаатар хотын төвлөрлийг задлах зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа хувийн сургуулиудын хувьсах зардлыг 38,500.0 сая төгрөгөөр бууруулж, Хөдөө орон нутгийн дотуур байрны хангамжийг сайжруулах, нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 38,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. БСШУСБХ дэмжээгүй байна, энэ асуудалтай санал байна шүү. Тийм учраас энэ Сайнзориг гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 1 ч гишүүн дэмжээгүй байна.

9 дэх санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай Төслийн 1 дүгээр хавсралтын “Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн 13.1.4 дэх заалтад “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн”-гийн нэршлийг “Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Ёс зүй, дэгийн байнгын хороо дэмжсэн санал. Гишүүний саналаар дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад орж, 7 гишүүн дэмжиж, 31,8 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

10 дахь санал. Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцын урсгал зардал дахь Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын сайдын урсгал зардал дахь сургуулийн өмнөх боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилтийг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм. Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Сангийн сайд тайлбар хийе. Боловсролын сайд тайлбар хийе. Баатархүү сайд. Инновацын сайдынх юм уу? Инновацын сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд тайлбар хийе.

Ц.Баатархүү: Төсвийн хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хороон дээр цэцэрлэгийн багш нарын гүйцэтгэлийн урамшуулал дээр мөнгө нэмье гэдэг томъёоллоор санал оруулж ирсэн. Энэ бол 2020 онд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлаад радио, телевизийн хүүхдийн танин мэдэхүйн ийм түүх, соёлын бүтээл үйлдвэрлэх ийм санг байгуулаад, 2022 он, 23 он, 24 онд ингээд манай энэ холбооныхон хөөцөлдөж байгаад энэ жил ингээд нэг төсөвтэй болж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Болохгүй юм байна тийм үү, гэдгээ л хэлчих.

Ц.Даваасүрэн Тэгээд энийг ингээд энэ саналыг та бүхэн маань дэмжихгүй байх ёстой. 2 дугаарт Наранбаяр сайд маань манай дээр энэ төсвийг шилжүүлэх

шаардлагагүй гэдгээ албан ёсоор мэдэгдсэн. Тийм учраас энийг битгий дэмжээрэй гэж та бүхнээсээ хүсье.

Ц.Даваасүрэн: Ундрам гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж 4,5 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

11 дэх санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, суурь түвшин “35281” гэснийг “172963” гэж, 2025 оны зорилтот түвшин “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 36,4 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Аль дээр нь юм бэ? Хураагдаад дэмжигдсэнгүй шүү дээ. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр гишүүдээ энэ ийм юм байгаа юм. Та бүхэн Засгийн газраас тодорхой үр дүн шаардаж байгаа. Тэгээд энэ бол ямар нэгэн төсөвтэй холбоогүй, төсөв дагасан нөгөө ийм шалгуур үзүүлэлтүүд байгаа шүү дээ, одоо сүүлийн 6 санал хураалт төсөв дагасан энэ шалгуур үзүүлэлтүүд байхгүй юу. Тийм учраас төсөв дагасан энэ шалгуур үзүүлэлт дээр бид нарын нөгөө шалгуур үзүүлэлтүүд, хэмжих нэгж, суурь он, хүрэх түвшин гэдэг дээр бид уг нь тоогоо 3 дахин л нэмж байгаа асуудал юм байгаа юм шүү дээ. Энэ хөдөлмөрөөс, халамжаас хөдөлмөрт шилжье гэдэг тоо 35 мянган хүнийг халамжаас гаргая гэхээр та нар гаргахгүй гэдэг санал хураалтад байх юм. Тэгээд хүнсний талоноо өгсөөр л байх юм уу? Энийг ингээд тайлбар хэлэхгүйгээр сая яачихлаа. 1 гишүүн нь юу яачхаач.

Ц.Даваасүрэн: Дэмжигдээгүй шүү дээ.

Л.Энх-Амгалан: Харин 1 гишүүн юу яачхаач. 1 гишүүн зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргаад ингээд яачхаач. Цөмөөрөө нэг иймэрхүү логикийн алдаатай юмнууд бид батлаад явуулаад байж болохгүй шүү дээ. Энэний дараа дахиад 6 санал хураалт болох гэж байна. Энэ дандаа ингээд энэ салбарын үзүүлэлттэй холбоотой, хүрэх түвшин, зорилт юуг дандаа сайжруулж байгаа ийм зорилтот түвшнүүд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та бүхэн нэг анхаарлаа хандуулаад дэмжээд өгөөч. Энэ дээр яагаад ийм алдаа гарсан юм бэ гэхээр төсөв өргөн барихтай холбоотой нэг ийм жаахан тоонууд нөгөө хэмжих нэгжүүд дээр жаахан ийм залруулга хийх шаардлага гарсан юм. Тэгээд энэ ямар нэгэн төсөвтэй холбоогүй юм байгаа юм.

Ц.Даваасүрэн: Засгийн газрынхаа тодорхойлсон энэ зорилтот түвшнүүдийг тэр тусмаа сайжруулах гэж байгаа энэ түвшнийг бууруулж битгий өөрчилж өгөөч гэж байгаа нь зөв байх. Энийг гишүүд анхааръя.

12 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.1 дэх дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “5” гэснийг “3” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхар. Нийгмийн

бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,9 хувиар дэмжигдсэн байна. Батбаяр гишүүн дэмжсэн юм байна. Дэмжсэн саналуудыг нь дэмжээд өгөөч гэж байгаа юм байна тийм үү? Дэмжсэн саналуудыг нь дэмжээд өгөөч гэж байгаа юм байна шүү.

13.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.2 дахь дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “16” гэснийг “12” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар уг санал дэмжигдлээ.

14 дэх санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.2.1 дэх дэд заалтын суурь түвшин “9386” гэснийг “1126” гэж, 2025 оны зорилтот түвшин “10500” гэснийг “1200” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сулпхар. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдлээ.

15 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.3.2 дахь дэд заалтын суурь түвшин “36” гэснийг “16.7” гэж, 2025 оны зорилтот түвшин “40” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сулпхар. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар энэ санал дэмжигдлээ. 17 дахь санал, дэмжсэн. Цогтбаатар гишүүн дэмжсэн байна.

12 дахь санал дээр тодруулга хийе гэсэн юм байна. Нөгөө Монгол улсын 25 оны төсвийн тухай хуулийн, 16-г хураалгасан биз дээ, 16-г хураалгаагүй юм уу? 16.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.6.1.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Нийт гэр бүлд гэрлэлт цуцлалтын эзлэх хувь хэмжээ” гэснийг “Нийт гэр бүлд гэр бүлийн талаарх сургалтад тэнхим, цахимаар хамрагдсан гэр бүлийн эзлэх хувь”, суурь түвшин “2.2” гэснийг “0” гэж, 2025 оны зорилтот түвшин энэ чинь одоо тэмдэг нь юу гэж байгаа вэ? “<2.2 буурна” гэснийг “20” гэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 45,5-аар уг санал дэмжигдсэнгүй.

17 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нийслэлийн Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал. Энэ чинь нөгөө өөрөө, тэгвэл Амарсайхан сайдын саналыг сонсьё, микрофоныг нь.

С.Амарсайхан: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ 25 оны төсвийн тухай хууль дээр туссан Налайх дүүргийн дулааны станцын эхний эх үүсвэрийг барих 56 тэрбум төгрөгийн 25 онд санхүүжих дүн нь 16 тэрбум гэснийг энэ эмнэлэг нь бүүр ямар ч шаардлага хангахгүй болчихсон байгаа учраас төсөвт хөрөнгө, өртөг, санхүүжих дүнд ямар нэг өөрчлөлт орохгүйгээр Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн төслийг хэрэгжүүлэх гэдгээр нэршлийг нь өөрчилж байгаа юм.

Тэгээд энэ Байнгын хороон дээр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр энэ зураг төсөв дутуу гэсэн ийм буруу ойлголт, буруу мэдээллээр явчихсан юм байна лээ. Энэ ЭМЯ-наас бичиг нь ирчихсэн, зураг төсөвтэйгөө, энэ дээр ямар нэгэн дүн өөрчлөгдөж байгаа зүйл байхгүй. Ингээд нэршлийг нь өөрчилж томъёолол зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа учраас та бүхэн маань дэмжиж өгөөрэй гээд. Энэ гар хүрэхгүй байхад л болох юм байна лээ.

Ц.Даваасүрэн: Энэ дээр ийм юм байна шүү. Хүчин чадал байхгүй, зураг төсөв байхгүй гэсэн нэг юм энийг нь тодруулъя. Энд хариулт өгчих, Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Зураг төсөв энэ Эрүүл мэндийн сайдаас бичиг нь ирчихсэн. Зураг төсөвтэй. Тэгээд зайлшгүй энэ чинь нөгөө дүгнэлт гарчихсан, буулгах нураахаас өөр аргагүй гээд, энэ мөөгөнцөрт идэгдсэн, шинжилгээ з... гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Эмнэлэг юм байна шүү дээ тийм ээ?

С.Амарсайхан: Эмнэлэг, тийм.

Ц.Даваасүрэн: Амарсайхан гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Биш ээ биш, тийм биш, дэмжих ёстой байсан байхгүй юу. 22 гишүүн санал хураалтад оролцож, 3 гишүүн дэмжиж, 13,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Биш, биш, тэгж хураалгахгүй байхгүй юу. Гишүүний саналаар хураалгаад байна шүү дээ би. 18.Төрийн албан хаагчийн цалинг, Цогтбаатарын саналыг яаж болох юм уу? Тийм, дандаа би тэгж хураалгаад байгаа шүү дээ. Гишүүний саналаар гэж хураалгаад байгаа байхгүй юу. Би зөв хэлсэн л дээ, гишүүний саналаар гэж би тийм. Гишүүний саналыг дэмжье гэж хураалгаад байхад чинь. Чи өөрөө буруу хэлчихсэн байна шүү дээ. Цогтбаатар, Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Санал хураалтад оролцох гэсэн боловч энэ санал хураах төхөөрөмж маань ажилласангүй. Тэгээд саяын саналыг хүчингүйд тооцох санал хураалт хийлгэж өгнө үү.

Ц.Даваасүрэн: Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналаар саяын 17 дахь саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар горимын санал дэмжигдсэн байна. Горимын санал дэмжигдсэн тул 17 дахь саналыг дахин хураалгая. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нийслэлийн Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан.

Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, энэ санал 72,7 хувиар дэмжигдлээ. Тэгэхдээ энэ дээр нэг юм анхаарахгүй болохгүй. Яг станцын барилгатай эмнэлгийн барилгын дүн яг тэнцэнэ гэж юм байхгүй шүү дээ. Тэгэхээр энийг та нар дараа нь нэлээн нягтлах хэрэгтэй шүү.

18.Төрийн албан хаагчийн цалинг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг хэмнэсэн 219.0 тэрбум төгрөгийг Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах. Үүнд:

1/Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл

2/Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл

3/Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл

4/Улаанбаатар хотын төвийн дулаан хангамжийн төсөл

5/Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, 4,5 хувиар уг санал дэмжигдсэнгүй. 19 дэх санал болохоор Үүрийнтуяа гишүүний нөгөө нэг цэцэрлэгийн хүүхдийн хоолны 31,4 мөн байна. Үүрийнтуяа гишүүнээ. Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Наадах чинь дахиад юун дээр 2 Байнгын хорооноос гадна дахиж орж ирээд байгаа юм уу дарга? Ажлын хэсэгт өгсөн санал давхардаж орж ирж байгаа юм болов уу? 31,4 тэрбум төгрөгийн төсөвтэй холбоотой асуудлыг хассан. Дагах нэг тогтоол дээр л байгаа.

Ц.Даваасүрэн: Ижилхэн байна нөгөө 31,4 чинь байна.

Д.Үүрийнтуяа: Тэгвэл энэ саналаа татъя.

Ц.Даваасүрэн: Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналаа Үүрийнтуяа гишүүн татаж байна. Энэ санал татагдлаа. 20 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн” гэснийг “Байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо” гэж, 2025 оны зорилтот түвшин “14564” гэснийг “15154” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүний санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 31,8 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

21 дэх санал. Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 2025 онд шинээр нэмэгдэх орон тоог 30 хувиар бууруулж, буурч байгаа орон тоотой холбоотой бусад урсгал зардлыг

холбогдуулан бууруулах замаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг бууруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын XI.1, XI.2, XI.3, XI.4, XI.5, XI.6 дахь хэсгийн “тоног төхөөрөмж”-ийн төсөвт өртөг болон санхүүжих дүнг нийт 21,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, ХЗБХ дэмжсэн санал байна. Энэ өмнө хураагдсан санал шүү гишүүдээ. Уг саналыг дэмжье гэсэн, Нарантуяа-Нара гишүүн байгаа юм уу? Байвал уг нь татчихмаар байна, байхгүй байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, 4,5-аар уг санал дэмжигдсэнгүй.

22.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 9,800.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны норматив зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. ХЗБХ дэмжсэн санал. Энэ их төвөгтэй санал байна шүү. Нэг юу нь, юу руу нь, нөгөө рүү нь шилжүүлж байгаа энэ болохгүй санал байна. Энэ саналыг гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, 18,2 хувиар санал дэмжигдсэнгүй.

23.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 991.0 сая төгрөгөөр бууруулж, Авлигатай тэмцэх газрын даргын томилолтын зардлыг 533.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 112.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 345.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, ХЗБХ дэмжсэн санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Тайлбар өгөх үү? Цахим хөгжлийн сайд тайлбар өгье.

Ц.Баатархүү: Та бүхэндээ дахиад өдрийн мэнд хүргэе. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан гэдэг маань харилцаа холбооны зөвшөөрөлтэй компаниудын ашгийн тодорхой хувиар бүрддэг, хувийн хэвшлээс мөнгөө бүрдүүлдэг сан. Төсвөөс огт мөнгө авдаггүй. Хяналтын зөвлөл хууль энэ тэр нь зөвхөн алслагдсан бүс нутагт, хөдөө орон нутагт хөдөлгөөнт холбооны сүлжээ тавих зориулалттай сан. Ийм учраас энэ саналыг дэмжиж болохгүй. Бид хууль зөрчих гээд байна гэдгийг та бүхэндээ хэлье. Дэмжих шаардлагагүй.

Ц.Даваасүрэн: Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 1 гишүүн дэмжиж, 4,5 хувиар уг санал дэмжигдсэнгүй. 24 бас л саяын саналтай төстэй юм байна шүү. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 620.5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын томилолтын зардлыг 420.5 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 200.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, ХЗБХ дэмжсэн санал байна. Бас л саяынх шиг зөрчилтэй санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 1 ч гишүүн дэмжсэнгүй уг саналыг.

25 дахь санал. Сангийн сайдын төсвийн багцын Сангийн яамны хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 5,065.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг дараах дурдсан дүнгээр нэмэгдүүлэх. Үүнд:

1.Цагдаагийн ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 2,900.0 сая төгрөгөөр;

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 245.0 сая төгрөгөөр;

3.Хуулийн хэрэгжилтийг хангах ерөнхий газар гэж байгаа юм уу? Хил хамгаалах ерөнхий газрын байр ашиглалтын зардал 1,000.0 сая төгрөгөөр;

4.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас санхүүжилтийг 920.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлье гэж байгаа юм шиг байна тийм үү? Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, ХЗБХ дэмжээгүй санал байна шүү. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 1 гишүүн дэмжиж, 4,5 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

26.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын Хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 4,055.0 сая төгрөгөөр бууруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, ХЗБХ дэмжээгүй санал байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 1 ч гишүүн дэмжсэнгүй. Энэ санал дэмжигдсэнгүй.

27.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах” гэсэн агуулгатай 38.1.2.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “780” гэж, Зорилтот түвшин “300” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүнт гишүүн дэмжиж, 59,1 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

28.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 17.1 дэх заалтын 17.1.1 дэх дэд заалтад “төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт” гэсэн агуулгатай 17.1.1.3 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “20” гэсэн арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 14 гишүүнээ дэмжиж, 63,6 хувиар энэ санал дэмжигдлээ. Хураагдчихсан юм чинь.

29. 29 дээр үү? Би уншчихъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.25.Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.18 км хатуу хучилттай автозамын санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Баянхонгор аймгийн төвд баригдах Дулааны цахилгаан

станцын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээний санхүүжих дүн 3,000.0 сая төгрөгөөр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Гишүүдээ энэ ийм зохицуулалт хийж байгаа ийм саналууд дээр маш анхааралтай байгаарай. Жишээ нь энэ Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54км замыг тухайн үедээ энэ чинь бараг л энэ замгүй бол энэ аймаг байхгүй сөнөлөө гэж тайлбар хэлж байгаад энэ тавигдаж байсан. Энэ төсөл нь ашгүй эзэнтэй болоод ингээд нэг явж байгаа юм байна лээ. Хөөрхий нэг компани орчихсон л үзэж тарж байгаа шүү дээ. Хойтон тэдийг авна гэчихсэн, аягүй бол зээл авчихсан ингэчихсэн л явж байгаа. Тэгж бөөн юм болж, болж тавьчихангуутаа дараа нь хэдэн талаас нь ингээд хэмлээд, хэмлээд бүр энэ төсөл ч байхгүй, юу ч байхгүй нэг ийм хэдэн балгас үлддэг шүү дараа нь.

Энэ Баянхонгор аймгийн, Баянхонгор аймгаас гадна хэд хэдэн аймгуудын энэ нөгөө баригдаж байгаа Солонгосын хөнгөлөлттэй зээлээр баригдаж байгаа дулааны станцуудын 2 дугаар хэлхээг нь Монгол Улс өөрөө хариуцаж хийх ёстой юм байгаа юм. Төсөв өргөн барих үед энэ Баянхонгор аймгийн төвд баригдаж байгаа ДЦС-ын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээний энэ зураг төсөв бэлэн болоогүй, одоо ч ирээгүй байгаа бид дээр албан ёсоор. Тийм учраас нэг явж байгаа төслөө ингэж хэмлэж хаяад, цөмөөд, жиргээд тэгээд зураг төсөв нь ч бэлэн биш ийм юм руу аваачиж хиймэл ийм юм тавиад хойтон аягүй бол энэ нь хэрэгжихгүй. Тэгж байхаар хэрэгжиж байгаа төсвөө дэмжээд явах нь зөв шүү дээ төслөө. Тэгэхээр энэ санал бол иймэрхүү саналууд байж болохгүй. Иймэрхүү хэд хэдэн саналууд байна лээ.

Ц.Даваасүрэн: Энэ санал гаргасан гишүүн тайлбарлачхаарай. Энэ чинь тэгээд төсөвт өртөг байхгүй юм байна шүү дээ. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье. Даваагийн Цогтбаяр.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Солонгосын Эксим банкаар хэрэгжиж байгаа 10 аймагт дулааны станц барих ажлын барилгын ажил явагдаж байгаа. Тэгээд сая Сангийн сайд өөрөө тайлбарлаж хэллээ. Гадна шугам сүлжээ буюу 2 дугаар шугам сүлжээнийх нь ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ёстой. Тэгээд энэ төсөв өргөн барьж байх үед магадлал нь гараагүй байсан үнэн. Магадлалын ерөнхий дүгнэлт нь сая 11 сарын 19-нд гарсан учраас зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Аймаг өөрөө утаа нэлээн даамжирч байгаа асуудал байгаа учраас энэ саналыг дэмжүүлээд өгөөч. Шаргалжуутын зам 25 онд санхүүжих дүн нь 20 тэрбум төгрөг. Энэ 20 тэрбум төгрөгөөс 3 тэрбумыг нь аваад энэ ажил руугаа хийгээд, энэ дулааны шугам сүлжээнийхээ ажлыг давхар явуулахгүй бол бид.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Төсөвт өртөг нь?

Да.Цогтбаатар: Төсөвт өртөг нь 52 тэрбумаар магадлал нь ороод гарчихсан энэ баримт нь энд байгаа.

Ц.Даваасүрэн: Тэрийг нь бичихгүй болохгүй юм байна шүү дээ.

Да.Цогтбаатар: Би тэрийг нь үлдээчихсэн байна уучлаарай. Тэгээд энэ ажлаа давхар явуулж байхгүй бол дулааны станцын барилга нь бэлэн болчихдог, гадна шугам сүлжээнийх нь ажил байхгүй бол тэнд дахиад нэг хий жил ажил явахгүйгээр зогсох ийм ажил байгаа учраас энийг аймаг өөрөө санал гаргасан гэдгийг нь давхар хэлэх нь зүйтэй байх. Тэгээд Байнгын хорооны гишүүд дэмжээд өгөөрэй гэж хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 40,9 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

30.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 18.1 дэх заалтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого, төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 9,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

31 дэх санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1 дэх заалтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он: “2023” гэж, Суурь түвшин: “-” гэж, Зорилтот түвшин: “200” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 9,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

32 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийг 400.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургах, стандартыг ашиглаж хэвлүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох төсөлд 400.0 сая төгрөгөөр Эрчим хүчний сайдын урсгал зардалд нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүн, Энхцэцэг гишүүн микрофоныг нь өгье. Саналаа тайлбарлая, Энхцэцэг гишүүний микрофоныг өгье. Та өөрөө яасан юм уу, бүртгүүлсэн юм уу? Бүртгүүлээгүй бол гарахгүй шүү дээ.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ зарчмын зөрүүтэй санал бол хамтарсан Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 25 оны төлөвлөгөөнд орсон ийм ажил байгаа. Тэгээд өмнөх төсвийн үед яг энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргаад явж байсан. Чуулган дээр бүх гишүүд дэмжсэн. Гэхдээ би нөгөө хасах зардлыг нь болохоор Улаанбаатар хотынхоос гэхихсэн байсан учраас болохгүй юм байна

гэдгээрээ зарчмын зөрүүтэй саналаа ингээд хассан байгаа. Энэ удаа болохоор зарчмын зөрүүтэй саналаа ингээд дахиад гаргаад явж байгаа.

Тэгэхээр та бүхэн мэдэж байгаа. Сүүлийн жилүүдэд цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч, ард түмэн маш их хэмжээний хөрөнгө санхүүгийн хохирол амсаж байгаа. Дээрээс нь цахилгаан гүйдэлд цохиулж нас барж байгаа. Онцгой байдлын газраас авсан мэдээгээр сүүлийн 10 жилийн хугацаанд нийтдээ 8 мянга гаруй цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарч, 300-гаад гаруй тэрбум төгрөгийн хохирлыг ард түмэн амссан байна. 300-гаад хүн нас барсан байна. Мөн 200 гаруй хүн гэмтэж бэртэж, хөгжлийн бэрхшээлтэй болсон байна гэсэн ийм албан ёсны мэдээллийг авсан байгаа.

Тэгэхээр энэ асуудал болохоор Эрчим хүчний яам болон Барилга, хот байгуулалт 2 яамны хооронд хаягдаад байдаг юм. Барилгын дотор цахилгаан хангамж гэдэг утгаараа Барилгын яаманд харьяалагддаг юм. Тэгэхээр энэ дээр ийм хүндээ ээлтэй нийгмийг бий болгохын тулд ийм том хэмжээний тогтолцоог бий болгох ажлыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа. Энийг би ирснээсээ хойш хавраас хойш тасралтгүй ярьж байгаа. Тэгэхээр Төсвийн байнгын хорооны гишүүд маань энэ зарчмын зөрүүтэй саналыг дэмжиж өгөөрэй гэж хүсье.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд Засгийн газар тайлбар хийе.

Б.Жавхлан: Энэ дээр 2 асуудал байна. Эхлээд тэр хасах гэж байгаа гэж байгаа төсөв нь өөрөө байхгүй болчихсон шүү дээ, бүхлээрээ байхгүй болчихсон байгаа. Тийм. Тэр чинь бүүр тэг байхгүй юу. Тэгээс юм хасаж болохгүй 1 дүгээрт. 2 дугаарт тэр Эрчим хүчний үндэсний төв дээр Энхцэцэг дарга гишүүн сайн мэднэ дээ. Эрчим хүчний үндэсний төв дээр тэр норм норматив гээд эрчим хүчний салбарт хийгдэж байгаа бүх төсвийн хөрөнгө оруулалтуудаас гэрээ болгоноос 0,04 хувь буюу ингээд цуглуулахаар бараг 2 тэрбум төгрөг хүртэл цугладаг. Тэндээс үүнийг санхүүжүүлэх бүрэн боломжтой. Энийг зохион байгуулалт хий гээд та сайдад нь шаардлага хүргүүлээд, энэ дээр нь хяналт тавиад ингээд явах бүрэн боломжтой. Тэгэхээр энэ нөгөө нэг хасах дүн нь өөрөө байхгүй болчихсон шүү дээ.

Ц.Даваасүрэн: Энэ гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 9,1 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

32, 33 дахь санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийн 11,986.1 сая төгрөгийг 9,000.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал. Энэ санал бол хураагдсан санал байна. Ингээд явчхаж болно биз дээ. Заавал хураалгах ёстой юм уу? Заавал хураах юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах юм байна. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, 4,5 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

34 дэх санал. Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.5-д сургуулийн барилга 640 суудал, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 34 дүгээр хороо, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 15,795.2 сая төгрөг, сая төгрөг биз дээ, сая төгрөг шүү энэ. Буруу бичсэн байна. 2025 онд санхүүжих дүн 11,975.2 сая төгрөг гэсэн төсөл,

арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 1,800.0 сая төгрөгөөр бууруулж, сургуулийн өртгөлийн барилга 320 суудал, Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр сургууль, хэрэгжих хугацаа 2019-2027 он, төсөвт өртөг 7,113.1 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Батбаяр гишүүн саналаа тайлбарлая.

Д.Батбаяр: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ сургуулийн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн өргөтгөл нь 2019 онд эхэлчихсэн ажил байсан юм байна лээ. Тэгээд энэ үндэс дээр нь 1 тэрбум 800 сая төгрөг тавиад энэ ажлыг нь эхлүүлэе гэсэн ийм зорилгоор зарчмын зөрүүтэй санал гаргаж байсан. Энэ зарчмын зөрүүтэй санал гаргасныхаа дараа салбарын сайдтай нь зөвшилцөөд, тодорхой мэдээлэл авснаар яг энэ 19 онд эхэлсэн ажил яагаад зогссон бэ гэхээр зураг төсөл нь өөрөө алдаатай байсан учраас зогсчихсон 1 дүгээрт. 2 дугаарт нь гэрээ хийсэн байгууллагууд нь хуулийн байгууллагуудаар шалгуулаад явж байгаа гэсэн ийм мэдээлэл авсан. Тийм учраас энэ зарчмын зөрүүтэй саналаа эргэн татаж байна.

Ц.Даваасүрэн: Зарлагын хяналтын дэд хорооныхоо даргын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Татчихсан юм уу? Татчихсан юм байна, татсан юм байна. Саналаа татсан байна. Яг дэмжих гэж байна шүү дээ. Ингээд бусад Байнгын хорооноос Төсвийн байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хурааж дууслаа.

Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулна. Энийг чинь уншихад ямар хэцүү юм бэ. Энэ чинь хэдэн санал байгаа юм бэ? 4 санал уу? Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан санал юм байна шүү. Цогтбаатар юм уу, энэ тэгээд яагаад Цогтбаатар гээд биччихсэн юм, Лувсанжамц гээд бас биччихсэн юм байна шүү дээ. Цогтбаатар гишүүн. Энэ тэгвэл ингэнэ шүү дээ. Цогтбаатар гишүүн гаргаснаар унших юм байна шүү. Яагаад гэвэл нөгөө хорооны гишүүн гаргах ёстой.

Цогтбаатар гишүүний гаргасан санал юм байна. Зарчмын зөрүүтэй санал. 1. “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг энэ чинь юу юм байна. 6.1.1.1 чинь нөгөө Хууль зүйн сайдынх уу? Хууль зүйн сайдын нөгөө хүрэх дүн үү? Тэрийг нь бичихгүй бол энэ чинь болохгүй шүү дээ. Хууль зүйн сайдын нөгөө хүрэх дүнгийн үзүүлэлтийн 6.1.1.1 дэх “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн хувь” гэснийг “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Дараагийн санал мөн төсвийн, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын Хууль зүйн сайдын зорилтот түвшин юм уу? Зорилтот түвшний 7.1.5.1 дэх дэд заалтын “Хууль тогтоомжийн хэрэгжилт” гэснийг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал

хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 50 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад байгаа Хууль зүйн сайдын зорилтод түвшний 7.1.8 дахь заалтын “Зөвлөмжийн хэрэгжилт” гэснийг “Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж 54,5 хувиар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын сайд нарын зорилтод түвшин, Хууль зүйн сайдын зорилтод түвшний Төслийн 1 дүгээр хавсралтын 11.1.1.1 дэх дэд заалтын “суурь он 2022” гэснийг “суурь он 2023” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 19 гишүүн дэмжиж, 86,4 хувиар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Төсвийн тухай, 2025 оны төсвийн тухай хуулийн XIV.1.4.1.Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, био технологийн сургуулийг Дархан, Сэлэнгийн бүс рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Төвийн бүс/ гэснийг 800.0 сая төгрөгөөр бууруулж, XIV.1.4.2.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийг Хөшигийн хөндий рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Хөшигийн хөндий/ гэж 800.0 сая төгрөг гэж нэмж тусгах, бууруулах юм уу? Бууруулах бас бууруулах юм байна. 800, 800 сая төгрөгөөр энэ 2 зардлыг бууруулж байна. Тэгээд XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн зардлыг 1,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар. Энэ саналыг гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 31,8 хувиар энэ санал дэмжигдсэнгүй. Чуулган дээр сайн тайлбарлая.

Дараагийн санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн XVI.1.1.2.Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний 2025 оны санхүүжих дүнгээс 2,000.0 сая төгрөгөөр, XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний 2025 оны санхүүжих дүнгээс 7,950.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, Налайх-Чойр чиглэлийн авто замаас Баянцагаан сум хүртэлх хатуу хучилттай 64.4 км авто замын эхлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 33,017.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний 2025 оны санхүүжих дүнг 9,950.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Түрүүний 2 арга хэмжээний замын дүнг 9 тэрбум 950 сая төгрөгөөр бууруулаад, энэ замыг 9 тэрбум 950 сая төгрөгөөр нэмэгдүүлж байгаа юм байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаяр. Батбаяр гишүүн саналаа тайлбарлая.

Д.Батбаяр: Дахиад өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ аягүй ач холбогдолтой зам байгаад байгаа юм. Тэгээд энэ яаж байгаа вэ гэхээр нөгөө нэмэгдэхүүний байрыг солиод нийлбэрийн хэмжээ өөрчлөгдөхгүй гэдэг шиг яг адилхан энэ 5 дугаар бүс дотроо, мөн энэ салбар дотроо зөвхөн хийгдэж байгаа. Өөр салбарыг, салбарт оролцохгүй, өөр бүс рүү ингээд яваагүй энэ дотор нь зүгээр шилжилт хийж

байгаа ийм төсөв байгаад байгаа юм, ийм төсөл байгаад байгаа юм. Тэгээд энэ манай Төв аймгийнх манай Батжаргал гишүүн бид 2-ын хоёулангийнх нь дэвшиж сонгогдсон ийм тойргийн төсөл байгаа шүү. Та дэмжиж өгөөрэй гэж хүсье. 10-лаа байгаа манай Жавхлан гишүүн байгаа, Энхбаяр гишүүн байгаа. Тэгээд бүгдээрээ дэмжиж байгаа гэж ойлгож байгаа. Манай Дамдинням гишүүн дэмжиж байгаа гэж ойлгож байгаа.

Ц.Даваасүрэн: Гэхдээ энэ чинь шинэ төсөл болж байна шүү. Ингээд энэ саналыг, Батбаяр гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 40,9 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Батбаяр гишүүн дэмжсэн юм байна. Тэгэхдээ л хүрэхгүй юм байна.

Дараагийн санал. Энэ Аубакир гишүүн гаргасан саналаа их тодорхой болгож, дараагийнх дээр хураалгахгүй бол Төсвийн хуулийн хэд хэддүгээр зүйл нь мэдэгдэхгүй байна шүү. Монгол Улсын төсвийн тухай, 2025 оны төсвийн тухай хуулийн “Сервис центр-2” дэд бүтцийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 14, 16, 18 дугаар хороо/, төсөвт өртөг 6,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,039.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Ногоон гудамж, дэд бүтэц /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, төсөвт өртөг 2,898.3 сая төгрөг, санхүүжих дүн 898.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир. Дэмжье гэсэн саналын томьёолол. Аубакир саналаа тайлбарлая.

Т.Аубакир: Би тайлбарлачихъя. Энэ ингэж байгаа юм. Чингэлтэй дүүрэг дээр хийгдэж байгаа ажил. Төсөвт өртөг нэмэгдэж барьсан юм ерөөсөө байхгүй. Тэгээд 1 төсвөөс нь тэрбумаар бууруулаад, нөгөө төсөл нь ажил нь сайн явж байгаа учраас хийгээд өгөөч гээд тойргийнх нь гишүүдийн хэлсэн санал шүү. Чингэлтэй дүүрэг дотроо л болж байгаа явдал. Тэгээд уг нь саяынхтай адилхан л даа. Тэгээд та өөрөө эсрэг өгчихье. Шинэ биш шүү. Үргэлжилж байгаа шүү. Бид нэг зарчим тохирсон шүү дээ. Бид нар нэг зарчим тохирч байгаа шүү дээ. Булгантуяа гишүүний хийж байгаа ажлаас Аубакир авч болохгүй. Өөр салбараас өөр салбарт шилжүүлж болохгүй гэдэг зарчмаа бид бариад явж байгаа. Тийм учраас дүүргээс нь сонгогдсон гишүүний гаргасан саналыг би энд санал гаргаж оруулж байгаа. Байнгын хорооны гишүүний хувьд. Тэр зарчмаа бид мэднэ шүү дээ өмнө нь ажиллаж байсан учраас. Дэмжээд өгөөрэй.

Ц.Даваасүрэн: Аубакир гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Минийх улаачихлаа. Би горимын санал гаргаад, сая миний төхөөрөмж алдаатай ажилласан учраас саяын саналыг дахин хураалгая, хүчингүй болгож дахин хураалгая гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, горимын санал дэмжигдсэн учраас Аубакир гишүүний гаргасан саналыг дахин хураалгая. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар уг санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Зам, тээврийн сайдын багцын, 2025 оны төсвийн тухай хуулийн XVI.1.1.75.Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомтын юу гэнэ вэ? Хавиргын боомтын хүртэлх хатуу хучилттай авто зам төслийн санхүүжилтээс 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын

сайдын Биеийнтамир, спортын хөтөлбөр, арга хэмжээний Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлыг 5,000.0 сая, энэ чинь хөрөнгө оруулалтыг урсгал зардал руу болчхоод байна шүү дээ, нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа. Дэмжье гэсэн, Булгантуяа гишүүн саналаа тайлбарлая.

Х.Булгантуяа: Тэгвэл саналаа өг л дөө. Үндэсний шигшээ багийн ерөнхийдөө нийт бараг зардлыг тэр чигээр нь хасчихсан юм байна. Ингээд ирэх жил бол тэрний дараагийн онд өвлийн олимп болох гэж байгаа. Үндэсний шигшээ баг ирэх онд ямар ч нөгөө qualify хийх тив дэлхийн, Азийнхаа тэмцээнд явах зардалгүй болтол нь хасаад ороод ирчихсэн юм байна. Тэгэхээр арай ч хэмнэлт хийлээ, хийлээ гэхэд. Тэр хасах гэж байгаа зам нь 180 хэдэн тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, ирэх онд 40 хэдэн тэрбум төгрөгийн санхүүжих дүн тавигдчихсан байгаа. Тэгэхээр тэр нь, тэрнээс хаслаа гээд тэр төсөл тэр чигээрээ зогсоно гэж байхгүй шүү дээ. 180 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй зам байхгүй юу. Тэгэхээр ямар ч байсан энэ шигшээ багийн үйл ажиллагааг бид явуулах ёстой. Энэ дээр манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ч гэсэндээ шигшээ багийн тамирчдын зардал хамт явдаг. Ийм үндэслэлээр зарчмын зөрүүтэй саналыг гаргасан юм.

Ц.Даваасүрэн: Тайлбар өгье, Жавхлан сайд тайлбар өгье.

Б.Жавхлан: Энэ хэдүүлээ оруулж ирсэн замуудаа ер нь бүгдийг нь сэглээд, сэглээд ер нь зам ч үгүй, юу ч үгүй боллоо доо. Яах вэ би тэр спортын асуудлыг би онцолж хэлмээргүй байна. Зүгээр замуудаа ингээд сэглээд байж болохгүй шүү. Аягүй чухал, чухал энэ бол боомтын зам шүү дээ. Боомтын зам, экспортын зам. Үүгээр тэгээд хэчнээн хэмжээний нүүрс гаргана, төчнөөн хэмжээний л спортыг бид санхүүжүүлэх боломж нээгдэнэ 1 дүгээрт.

2 дугаарт тэр спортын гэж байгаа дээр би зүгээр нийтлэг зүйл хэлье. Сайдын эрхлэх чиг үүрэг дотор Биеийн тамир, спортын улсын хороо гэж байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагч нь сайд нь, төсвийн шууд захирагч нь Биеийн тамир, спортын улсын хорооны дарга. Одоо яг салбарынх нь зардал 70 хэдээс билүү дээ 10 хувь буюу яг зарчмаар яг 10 хувь хасагдаад, 60 хэд болж байгаа юм. Түүн дотроо эдийн засгийн ангилал тус бүр дотроо.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ерөнхийдөө ойлгомжтой болчих шиг боллоо. Булгантуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 31,8-аар уг санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал хураалтыг явуулъя. Төсвийн тухай 2025 оны, Булгантуяа гишүүн түрүүний санал дээр протоколд тэмдэглэе, дэмжсэн юм байна шүү.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих интернет шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/ гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 9,8 тэрбум төгрөгөөр бууруулж байгаа юм уу Ганбаатар гишүүнээ? Байна уу, тийм үү? 9,816.6 сая төгрөгөөр бууруулж, Барилга үргэлжлүүлэн барих 2019 онд эхэлсэн Өмнөговь, Цогтцэций сум, 960 хүүхдийн сургуулийн барилга мөн дүнгээр 9,816.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт, саналаа тайлбарлах юм байна. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Энэ яах вэ, ийм л учиртай юм. Манай говийн бүсийн ялангуяа Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сургууль түрүү долоо хоногт нурчихсан юм. Уг нь хуучин нэг сургууль 21 оноос хойш барьж байгаад тэгээд тэр компани нь хариуцлагагүй байх шиг байгаа юм. Дээрээс нь нөгөө магадлангаар ороод энэ чинь урьд нь явж байсан ажил байхгүй юу 2, 3 жил. Тэгээд магадлангаар ороод 6, 7 орчим тэрбум байсан нь нөгөө 9,8 л болсон юм билээ. Тэгээд энэ дээр нэмэлт тайлбарыг нь болохоор манай Сэддорж гишүүн их дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Өөрөө тэр үед аймгийн удирдлагаар нь ажиллаж байсан. Үнэндээ Цогтцэций, Өмнөговь аймгийн Цогтцэций сум хүүхдүүд нь 3 ээлжээр хичээллээд, сургалтын орчин маш хүнд болчихоод байгаа. Гэтэл Өмнөговь аймаг, тэгж байгаа тийм. Дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсье.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүний гаргасан горимын, биш ээ горимын гэнэ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцоноос 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар уг санал дэмжигдсэн юм байна. Ганхуяг гишүүн дэмжсэн юм байна, Батбаяр гишүүн дэмжсэн юм байна, протоколд авъя.

Дараагийн санал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн энэ муу замыг яах нь вэ дээ, чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ гэсэн замын энэ онд санхүүжих дүнг юм уу? Бууруулах дүн гэж байна шүү дээ, энэ чинь юу вэ. Юунаас нь бууруулж байгаа юм бэ? Энэ чинь бүр алаад хаясан юм байна. Төсөвт өртгийг нь юм уу, санхүүжих дүнг нь юм уу Ганбаатараа? Энийгээ татсан нь дээр. Ганбаатар гишүүн татахгүй бол Сэддорж гишүүн манай Байнгын хороо биш учраас болохгүй юм. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Яах вэ тэгээд төсвийг нь Сангийн яам аймагт нь тэгвэл үлдээчих л дээ. Жавхлан сайд байна уу? Тийм. Орон нутаг дээр нь, тэр нөгөө Цогтцэций сумын нөгөө сургууль нь нурчхаад 9,8 тэрбумын. Үгүй ээ тэгээд яах вэ.

Ц.Даваасүрэн: Би энэ саналыг та бүхэнд танилцуулаадахъя. Дараагийн санал. Монгол Улсын төсвийн тухай хуулийн, 25 оны төсвийн тухай хуулийн XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ гэсэн төслийн 30 тэрбум, энэ тэрбум юм уу сая төгрөг юм уу? 33,533.9 сая төгрөг гэсэн дүнг бууруулж, Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай автозамын дуусгал /Говийн бүс/ гэсэн төслийн санхүүжих дүнг 33,533.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн санал юм байна. Энэ чинь үндсэндээ нэг замын бүх мөнгийг нөгөө зам руу шилжүүлчхэж байна гэсэн үг. Тэгэхдээ би хураалгая, энийг анхаараарай гишүүдээ. Ганбаатар гишүүний гаргасан энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн орсноос 3 гишүүн дэмжиж, 13,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Хамгийн сүүлийн санал уу?

Хамгийн сүүлийн санал гишүүний гаргасан. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн XVII.1.1.3.Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/, 1,481.2 сая төгрөг гэсэн төсөвт өртөгтэй юм уу, юу нь юм бэ? Тэгээд санхүүжих дүнг 481.2 сая төгрөгөөр бууруулж, Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/, төсөвт өртөг 1,845.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүн, энэ шинэ юм байна уу шүү дээ. 2025-2027 он санхүүжих

хугацаа, 2025 онд санхүүжих дүнг 481.2 сая төгрөг гэж нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, 13,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Тайлбар хэлэх юм уу? Мөнхтулга гишүүн яах вэ тайлбараа хэлье. Чуулган дээр хэдүүлээ дахиад ярья л даа. Мөнхтулга гишүүний микрофоныг өгье.

П.Мөнхтулга: Энэ ийм юм байгаа юм. Нэгд тойрог дотроо, 2-т сайд дотроо, сайдынхаа багц дотроо юм. Тэгээд 400 сая төгрөгийг 2 ажлын хооронд л шилжүүлж байгаа юм. Яагаад вэ гэхээр.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Гэхдээ шинэ ажил юм байна шүү дээ.

П.Мөнхтулга: Яагаад вэ гэхээр юу нь энэ жил сэргээн засахгүй бол манай төсөв дээр соёлын өвийг сэргээж байгаа нэг ч юм байхгүй. Тэгээд энэ жил сэргээн засахгүй бол энэ 16 дугаар зууны үеийн Луу гүний хошуу Тунгалаг тамир кинон дээр гардаг тэр юм маань дахиж манай хүүхдүүд үзэхгүй гэсэн үг. Тэгэхээр 400-хан сая төгрөгийг хэдүүлээ энэ 16 дугаар зууны үеийн түүх соёлын төвөө, өвөө аваад үлдчихье л гэж байгаа юм. Тэгээд тойрог дотроо, сайдын багц дотроо байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Яах юм бэ тэгээд?

П.Мөнхтулга: Тэгээд саяын саналыг нэлээн олон гишүүдийн төхөөрөмж нь ажиллаагүй учраас хүчингүй болгоод, дахиж санал хураалгах горимын санал гаргачихъя.

Ц.Даваасүрэн: Мөнхтулга гишүүний гаргасан горимын саналаар саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар горимын санал дэмжигдсэн тул сая Мөнхтулга гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй 50 хувиар. Тэгвэл дахиад, одоо ерөөсөө хамгийн эцсийнх шүү. Тийм ээ тийм, сая ингээд санал тэнцсэн учраас дахиад уначхаж байгаа байхгүй юу. Тэгээд Аубакир гишүүн горимын санал гаргая.

Т.Аубакир: Би сая энэ төхөөрөмждөө амжсангүй. Батцэцэг сайд бид 2-ын санал эсрэг гарчихсан байна. Нэг бол дэмжсэнээр авч протоколд өгөөч, үгүй бол дахин санал хураалгаж өгөөч гэсэн.

Ц.Даваасүрэн: Дэмжсэнээр авч, санал хураалтыг дэмжсэнд тооцож болохгүй. Тийм учраас Аубакир гишүүний гаргасан горимын саналаар саяын саналыг дахин хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар Аубакир гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн тул Мөнхтулга гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор хамгийн сүүлийн дахин санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж 59,1 хувиар энэ хийдийг сэргээн засварлах санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар

санал хураалт явуулж дууслаа. Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг бусад Байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг миний бие чуулганд танилцуулъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

13.39 цаг

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Хэвээрээ, өмнөх хэвээрээ шүү. Улсын Их Хурлын даргын 2025 оны 303 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн танилцуулгыг Тэмүүлэн гишүүн хамтад нь өглөө хийчихсэн байгаа. Монгол Улсын Их Хурлын хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу БСШУС-ын байнгын хороо, ТББХ, Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хууль, тогтоолын төслүүдийг, бүх Байнгын хороо Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэхээр заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Дээрх хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлтээ ирүүлснийг та бүхэнд тараасан. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл, хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр

зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Ямар санал байгаа юм бэ? Саналаа өгөөрэй. Аль саналууд юм бэ? Ганц байгаа юм уу, тийм үү, хэдэн санал байгаа юм бэ? 1 зүйлтэй холбоотой 4 саналыг хураалгая. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 22.5.22 дахь заалтын “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 11.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Ж.Золжаргал, М.Мандхай, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэх. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт, саяын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдсэн байна. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа.

2 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22.14 дэх хэсгийн “үйл ажиллагааны орлогод үзүүлэх бусад” гэснийг “үйл ажиллагааны орлогын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдсэн байна. Батжаргал гишүүн, Батлут гишүүн, Цогтбаатар гишүүн нарыг дэмжсэнээр авлаа.

3 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтад доор дурдсан агуулгатай 22.15 дахь хэсэг нэмэх.

“22.15.Энэ хуулийн 22.5.22-т заасан импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдлээ.

4 дэх санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 27.11 дэх хэсгийн “холбогдох олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид үндэслэн тооцож, зөвлөмжийн хамтаар” гэснийг “Монголбанкнаас зарласан тухайн татварын жилийн дунджаар тооцож, дараагийн татварын жилийн 1 дүгээр сард багтаан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар дэмжигдсэн байна. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан саналтай, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн, байгаа юм уу? Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Би ганцхан юм асуугаадахъя. Тэр 2 дугаар зүйлийн, 27.1.6 дахь заалтыг 1,7 их наядыг яагаад 750 сая евротой тэнцэх гэж нэмээд байгаа юм бэ гэж асуух гээд байгаа юм. Энэ ямар хэрэгтэй юм бэ?

Ц.Даваасүрэн: Тийм юм байгаа юм уу энэ дээр. Тэлмүүн хариулъя. 7 номерын микрофон Засгийн газар.

Г.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Гишүүний асуултад хариулъя. Энэ ЭЗХАХБ-ын гаргасан олон улсын стандарт. Манайх заавал дагаж мөрдөх үүрэг хүлээгээд гэрээнд нэгдэж орсон. 19 онд олон улсын стандартын дагуу 750 сая евро гэдэг ийм нөгөө тайлагнах ийм борлуулалтын орлогын босготой. 19 онд бид тухайн үеийнхээ ханшаар төгрөгөөр хөрвүүлээд 1,7 их наяд гэсэн. ОУБ-аас биднийг яг еврогоор илэрхийлж явахгүй бол нөгөө ханшийн өсөлтдөө жил болгон нөгөө еврогоор илэрхийлэх гэж байгаа дүн нь буураад байна. Тэгэхээр та хэд олон улсын стандартдаа нийцүүл гэдэг ийм шаардлага тавьсан. Тэгэхээр 750 сая евро, түүнийгээ тухай тухайн жилийнхээ албан ханшаараа ингэж хөрвүүлж бодохоор ингэж зохицуулж байгаа. Тэгэхээр бид ЭЗХАХБ-ын олон улсын стандартад нийцүүлж, еврогоор илэрхийлэх ийм зохицуулалтыг нэмж оруулж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Тайлбар авлаа. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

5.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 5 зүйлтэй. Зүйл тус бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдон зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал зарчмын зөрүүтэй ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайныг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Хөнгөлнө. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Ер нь нэг гишүүн л явалал баларчих гээд байна шүү. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар энэ санал дэмжигдлээ. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа. Төслийн дараагийн санал, төслийн 1 дүгээр зүйлд, Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Дараагийн санал. Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 38.7 дахь хэсэг нэмэх.

“38.7.Энэ хуулийн 38.4-т заасан татварын хөнгөлөлтөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, түүний тодорхойлолтыг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй, 5 дугаар зүйл. 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар санал дэмжигдсэн байна.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 2 зүйлтэй. Зүйл тус бүрээр хэлэлцүүлэг хийе. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Тав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл 3 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцье. Дээрх хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хорооноос хэлэлцээд санал, дүгнэлтээ ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналыг хураалгая. Ажлын хэсгээс гаргасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн “Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар, 2-ыг, 1 дээр. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 3 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар дэмжигдлээ. Батжаргал гишүүн, миний бие 2-ыг дэмжсэнээр протоколд.

Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцье. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдсэн байна. Батжаргал гишүүн, Мөнхсоёл гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Дээрх хуулийн төслийг БСШУС-н Байнгын хороо хэлэлцээд, санал, дүгнэлт ирүүлснийг та бүхэнд тараасан. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар энэ санал дэмжигдлээ.

8 дахь хууль. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Хуулийн төслийг бүх Байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлтээ ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа. Зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу, байна уу? Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Тэгэхдээ бид хэд зүгээр нэг зүйлийг бодмоор байна. Жишээ нь төрийн энэ хэмнэлт хийх зардал дээр спортын арга хэмжээ санхүүжүүлэхгүй л гэхихсэн байна лээ. Яах вэ тэгээд хэдэн төгрөг, яаж хэмнэгдэж байгааг би мэдэхгүй. Сүүлдээ яг энийгээ ингээд санхүүжүүлэхгүй болоод ирэхээр байгууллага болгон дэргэдээ заал барих тал руугаа явдаг ч юм уу нэг ийм юм руу явна даа. Тэгээд яах вэ зүгээр энгийн юм шиг мөртөө нэг Засгийн газрын цом гээд, ер нь байгууллагын ч гэдэг юм уу, ойн юугаар бөх барилдуулах ч арга хэмжээ зохион байгуулж болохгүй л гэсэн үг шүү. Энийг би ингээд хэт туйлшрахаараа ингээд нэг явчхаж байна. Ерөнхийдөө энэ спортыг дэмжих асуудал дээр төрийн байгууллага өөрөө л манлайлал үзүүлэх ёстой. Хамт олны уур амьсгал ч гэдэг юм уу нэг ийм зүйл дээр эерэг зүйл байдаг юм. Гэтэл ерөөсөө юу ч хийж болохгүй гээд ингээд хийчихсэн. Тэгээд яг хэчнээн төгрөгийн, ямар хэмнэлт гарах гээд байгаа нь их ойлгомжгүй.

2 дугаарт тэр жуулчны бааз, амралт сувилал дээр хурал зохион байгуулж болохгүй гэж байна. Зарчмын хувьд дэмжиж байна. Ашиг сонирхол гаргахгүй байхад л тэр зүйлээ анхаарах ёстой болохоос биш тэнд нэг хөрөнгө оруулалт хийгээд нэг жуулчин авах маягтай эсвэл нэг хурал зохион байгуулаад, хоол яагаад явж байгаа энэ бизнесүүдийг шууд ингээд төр чамаас худалдан авалт хийхгүй гээд ингэж болох юм уу? Хэт яг ингээд хавтгайрахаараа жижиг гэлтгүй нэг тийм сонин үзэгдэл рүү явчих гээд байна. Тэгээд бодолцоно биз дээ. Энийг тэгээд ажлын хэсэг энэ дээр ямар байр суурьтай байгаа юм бэ? Ингээд харахад нэг их аймар том зардал хэмнээд байгаа юм ерөөсөө алга. Эсвэл тэр спортын зардал энэ тэр дээр нь байгууллагынх нь тэр хүн хүчний тооноос нь шалтгаалаад жилд 1 удаа нэг ийм зардал гаргаж болно ч гэдэг юм уу, ингээд хийхгүй бол наадах чинь ингээд ер нь зүгээр хамт олны уур амьсгал гэлтгүй ингээд спортыг дэмжих нь өөрөө төрийн байгууллагуудад манлайлал үзүүлэх гэдэг ч юм уу, ерөөсөө л нэг тийм сонин логикгүй л байна. Сүүлдээ ингээд нэг ийм юу гэж хэлмээр ч юм бэ яг хэдэн төгрөг хэмнээд байгаа юм бэ, тэгээд үр дүн нь яг юу гэж хараад байгаа юм бэ? Би ерөөсөө сүүлдээ бүүр ингээд ойлгохгүй байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдолтой гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулна. Жавхлан сайд хариулах юм уу? Асуугаагүй. Асуусан юм уу? Хариулъя хэдэн төгрөг нэмж байгаа юм Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ийм юм байгаа юм. Хэдүүлээ өнгөрсөн хэлэлцүүлгээр зардал хасна гэж уралдацгаасан. Одоо хасахгүй гэдэг уралдаанаа эргээд явж байна. Эсвэл энийгээ бүүр болиод, бүүр анхныхаа хэлэлцүүлгээр дахиж өргөн бариулаад дахиад бүүр ингээд алдагдалтай төсөв рүүгээ явцгаая л даа эсвэл. Хэмнээ гэж байгаа дээр нь бушуухан батлаад өгөх хэрэгтэй шүү дээ. Одоо хэмнэж байгаа зүйл ч байгаа, ирээдүйдээ гарах зардлуудыг нь ч хэмнэж байгаа. Ийм төрлийн зардлууд дээр жишээ нь бид дотроо маш их асуудал үүсдэг. Бид төсөв боох гээд ингэхэд төсвийн ерөнхий захирагч нараас саналууд ирдэг. Түүн дотор иймэрхүү зардлууд их ирдэг. Тэрийг нь тэгээд дотроо нэлээн юм болно шүү дээ. Тэгээд нэлээн танаад л, хасаад л ингээд оруулж ирж байна. Тэрийгээ цааш нь ингээд хуульчилчих юм бол маш амар. Ийм зардал дахиж гарахгүй гэсэн үг. Би өөр юу хариулах вэ дээ.

Ц.Даваасүрэн: Ойлголоо. Гишүүдээ хэдүүлээ юманд ноён нуруутай тэгж хандахгүй бол, олон талаас нь хандаж байна гээд ерөөсөө бүгд янз бүрийн өнцөг гаргаад байвал ерөөсөө бидэнд нь нэгдсэн шийдэл гэдэг юм ерөөсөө гарахгүй шүү. Ийм юм энэ төсөв дээр ажиглагдаад байна. Энийгээ анхааръя. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад би Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор, Байнгын хороон дээр гарсан саналын томьёолол юм байна шүү гишүүний. Энэ яагаад юм уу?

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, 18,2 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.9 дэх заалт нэмэх:

“15.1.9.байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр, бусад тэмдэглэх өдрийг тэмдэглэх” гэж нэмэх. Байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр бусад тэмдэглэх өдрийг тэмдэглэх гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ. БОХХАА-н байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн дэмжиж, 9,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга. Уг зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүний санал хураалтад оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар уг санал дэмжигдлээ. Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Ес.Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Уг тогтоолтой холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Арав.Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байнгын хороодын саналыг тараасан байгаа. Алга байна. Уг тогтоолын төслөөр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Санал ирсэн юм байхгүй биз дээ Байнгын хороодоос, байхгүй юу? Тэгээд хураалгаач, яагаад хураалгахгүй байгаа юм бэ? Үнэт цаас дээр санал байхгүй байсан юм байгаа биз дээ? Байнгын хороодоос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсэг байгаа юм уу, тэрийгээ хураана шүү дээ. Эхлээд ажлын хэсгээ хураая. Ажлын хэсэг энэ үү?

Засгийн чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн тэмдэглэх хэсэгт Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. 2.Төслийн 1 дэх заалтын “, цаашид өөрчлөгдөхгүй байх” гэснийг хасах Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжээд уг санал дэмжигдээгүй учраас, минийх ажилласангүй учраас саяын саналыг хүчингүй болгоё гэсэн горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар горимын санал дэмжигдсэн тул саяын Төслийн 1 дэх заалтын “, цаашид өөрчлөгдөхгүй байх” гэснийг хасъя гэсэн саналын томьёоллоор дахин санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ. Батжаргал гишүүн, Мөнхсоёл гишүүн, Цогтбаатар гишүүн нарыг дэмжсэнээр авлаа.

Дараагийн санал. Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Дараагийн санал. Энэ дотроо 3.1 юм байна. 1/”бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, ур чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистик гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуульд тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах; Санал гаргасан ажлын хэсэг. Дараа жилээс юм байна шүү. Ажлын хэсгийн энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдлээ.

3.2. 2/төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид “бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” болон “бусад зардал” гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцох; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдсэн байна.

3.3. 3/олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдсэн байна.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4.Төрийн байгууллагуудын мэдээллийн системүүд, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар уг санал дэмжигдлээ.

6 дахь санал, биш ээ энэ чинь 5 дахь санал. Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

5.Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид нүүлгэх, нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судалж, жагсаалтыг гаргаж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж, холбогдох шийдвэр гарсны дараа худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдлээ. Би уг саналыг дэмжсэн болно. Энэ нөгөө эмнэлэг, тэгээд энэ их, дээд сургууль энэ тэрийг Удирдах зөвлөл гэж байгуулчхаад л газар, өмч хөрөнгийг нь шийдээд байгааг л юу юм байна тийм ээ, тэрэнтэй холбогдолтой шахуу юм байна тийм үү? Энийг Их Хуралд танилцуул гэж байгаа юм байна.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

6.Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын талаар нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдлээ. Мөнхсоёл гишүүнийг дэмжсэнээр авлаа.

7 дахь заалт. Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмэх:

7.Төсвөөс олгож буй бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих болон төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж, 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах. Энэ найруулгыг нь жоохон өөрчлөөрэй. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал

хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 72,7 хувиар уг санал дэмжигдсэн. Мөнхсоёл гишүүнийг дэмжсэнээр авлаа.

8.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдсэн байна. Мөнхсоёл гишүүнийг дахин протоколд, Мэндсайхан гишүүн, Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хороодоос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хэлж болохгүй юм байна лээ. Санал хэлж болохгүй юм байна лээ. Тайлбар хэлж болно, тайлбар л хэлэх юм байна лээ. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төсвийн ажлын хэсгийнхэн маань нэлээн ачаалалтай, богинохон ажилласан. Эндээс ингээд Хавдрын эмнэлгийг энэ төслийг яаралтай шүү, яаралтай нөгөө барилгын ажил маань нэлээн 3, 4 жил болоод явчихна. Тийм учраас цаг хугацаа алдахгүй яаралтай эхлүүлье гэж байгаа энэ зарчим дээр нь би зөв, дэмжиж байгаа. Харин хэдүүлээ энийгээ нэг хэрэгжүүлэх тал дээрээ зөв эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөхгүй бол хайран төсвийн орон зай ингээд тавьчихдаг. Тэрийгээ тэгээд ингээд юу ч биш болчих вий гэдгээс би санаа зовоод байна. Тийм учраас тэр тогтоол дээр Засгийн газарт чиглэл өгөх шинэ заалт нэмж оруулаад, Засгийн газар санхүүгийн түрээсээр хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглаж болох тийм шаардлага хангасан, бэлэн объектыг 5 жилийн дотор эзэмшилдээ бүрэн шилжүүлж авах байдлаар Түрээсийн санхүүгийн тухай хуулиар, хууль тогтоомжид нийцүүлээд, Худалдан авах ажиллагааны тухай хуульд нийцүүлээд ингээд хэрэгжилтийг хангах гэдэг юм уу юу гэдэг юм нэг ийм утгатай заалт тогтоолын төсөлд оруулмаар байна. Тэгэхгүй бол тэр Санхүүгийн түрээсийн тухай хууль маань хөдлөх хөрөнгүүд машин техник худалдаж авч байсан практикууд байгаа. Монгол Улсын төсвийн тухай хуульд анх удаа 90 оноос хойш ийм өндөр өртөгтэй байшин барилга энэ хуулиар худалдаж авах гэж байгаа байхгүй юу. Гэтэл энэ дотор маань өөрөө хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, тийм худалдаж авах эд хөрөнгийн зохицуулалт заалт байхгүй, тийм төгс биш байна. Тийм учраас хэрэгжүүлэх үе шатад эрсдэл үүсэх гээд байна. Тийм учраас энэ заалтыг нэмж оруулж өгөөч.

Ц.Даваасүрэн: Зарчмын зөрүүтэй саналыг Төсвийн байнгын хорооны гишүүн л гаргаж болно. Тийм учраас хэрвээ шаардлагатай гэвэл Төсвийн байнгын хорооны гишүүн санал хураалгаж болно шүү. Би Байнгын хороодоос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төсөл дээр шүү дээ.

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион

байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёолол санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 5 гишүүн дэмжиж, 22,7 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Тогтоолд байгаа юм байна гэж ойлголоо шүү. Тэрийгээ харин тогтоолоо яахдаа хэдүүлээ зүгээр 3 дахь хэлэлцүүлэг дээр найруулгын шинж чанартай байвал чиглэл аваад нэг үзье.

2.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 45,5 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

3 дахь санал. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

8.Цэвэр эрчим хүч, хогноос эрчим хүч гаргах асуудлыг зохицуулах, дэмжих, ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Тайлбар хэлье. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Сая өмнөх санал маань уг нь Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн. Энэ яамнуудын чиг үүрэгтэй давхцаад байгаа хуульд заагаагүй, хуулиар байгуулагдаагүй ийм ажлын хэсэг, комисс, хороодыг татан буулгая гэсэн харамсалтай дэмжихгүй байгаа юм байна. Хэмнэлт уг нь энэ зүйлээс л эхлэх ёстой.

Одоо энэ гаргаж байгаа санал маань үндсэндээ хогийн хууль, Хогийн тухай хууль байгаа юм. Хогийн хуулиар хогийг сэргээн ашиглах асуудал байгаа. Эрчим хүч гаргах асуудал байгаа боловч маш ерөнхий зохицуулалттай. Цаашдаа энэ цэвэр эрчим хүчний эх үүсвэр болох энэ АЦС-ыг ашиглах тохиолдолд ямар хууль эрх зүйн орчин бүрдүүлэх юм. Энэ чиглэлийнхэн судалгаа хийж, хууль, эрх зүйн орчны дүгнэлт хийгээч л гэдэг чиглэлийг Засгийн газарт өгч байгаа юм. Яг Сэргээгдэх эрчим хүчний хуулиар зөвхөн нар, салхи, био масс, газрын гүний хийн тухай яриад байгаа боловч яг бусад энэ 2 нөгөө цэвэр эрчим хүчний эх үүсвэр болон хогноос эрчим хүч гаргах асуудал жоохон ингээд орхигдчихоод байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг эрчим хүчний реформ яригдаж байгаа энэ үед Засгийн газарт чиглэл өгчихье гэж байгаа юм. Гишүүд маань дэмжээд өгөөрэй.

Ц.Даваасүрэн: Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар уг санал дэмжигдлээ. Дараагийн санал, өнгөрчихсөн алх цохичихсон.

4.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9 дэх дэд заалт нэмэх:

9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;" Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдсэн байна. Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолыг хэлэлцлээ.

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Энд 1 ажлын хэсэг юм уу? Байнгын хорооноос гарсан 1 санал байна.

Төслийн 1 дэх заалтын “-Ургамал хамгааллын газар” гэсний дараа “, Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Төмөр замын газар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. ТББХ дэмжээгүй санал байна. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 5 гишүүн дэмжиж, 20,7 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Хамгийн сүүлийн тогтоол. Арван хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Тогтоолын төслийг бүх Байнгын хороо хэлэлцсэн санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Гишүүдийн гаргасан саналаар санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн санал.

1.Тогтоолын төслийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож 10 гишүүн дэмжиж, 45.5 уг санал дэмжигдсэнгүй. Батжаргал гишүүн горимын санал.

Ж.Батжаргал: Саяын саналыг дэмжиж санал өгсөн боловч миний хурууны хээ уншигдсангүй. Санал эсрэг гарчихлаа. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар горимын санал дэмжигдсэн тул саяын саналыг дахин хураалгая. 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн

захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх; гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Дараагийн санал. 1.2. 2/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж, аудитын тайлан, Тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдсэн. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа.

1.3. 3/гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдлээ.

1.4. 4/шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, Бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжлээ.

5 дахь санал. 5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 50 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Мөнхсоёл гишүүн горимын санал уу? Энэ уначихсан учраас горимын санал гаргаж байна.

Б.Мөнхсоёл: Миний энэ төхөөрөмж сүүлийн хэдэн юман дээр ерөөсөө ажиллахгүй байгаад байна шүү. Горимын санал гаргаад саяынхыг хүчингүй болгоё. Дахин санал хураалгая.

Ц.Даваасүрэн: Мөнхсоёл гишүүний гаргасан горимын саналаар саяын саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, горимын санал 68,2 хувиар дэмжигдсэн тул 4 дэх саналыг шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүсчилсэн хөгжлийн, биш, 5 дахь саналыг. 5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах; гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор дахин санал

хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар энэ санал дэмжигдлээ.

6 дахь санал. 6/аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдсэн. Өөр санал байна уу? Тэгвэл энэ юуг дуусгачихъя, ажлын хэсгийн саналуудыг дуусгачихъя. Ажлын хэсгийн саналуудаа дуусгачихъя.

Дараагийн санал. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдсэн байна. Мөнхсоёл гишүүнийг сүүлийн 2 санал дээр дэмжсэнээр авлаа.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хороодоос ирүүлсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

6/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах; Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал. Гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдсэн байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмэх:

7/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн

захирагчид олгох. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар уг санал дэмжигдсэн байна.

3.Төслийн 1 дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм. БСШУС-ын байнгын хорооны дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 36,4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 1 дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Кино урлагийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир. БСШУС-ын байнгын хорооны дэмжсэн санал. Юу гэсэн үг юм бэ? Энэ саналыг хураалгана шүү дээ. Энэ саналыг л хураана шүү дээ би. Тайлбар хэлье. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хүчингүй болгочихъё, тайлбар сонсъё. Хүчингүй болголоо. Санал гаргасан гишүүний тайлбарыг сонсож болно. Бум-Очир гишүүн. Би хүчингүй болгоод хэлчихсэн шүү дээ яахаас нь өмнө. Бум-Очир гишүүн. Чи бүртгүүлсэн юм уу? Бүртгүүлээгүй л юм байна л даа. Чи өөрийнхөө нэрээр бүртгүүлэхгүй бол микрофон чинь нээгдэхгүй.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Өмнөх Ундрэм гишүүний гаргасан манай Байнгын хороон дээр яригдсан Боловсролын зээлийн сангийн мөнгө хасагдчихсан юм энэ жилийн төсөв дээр. Тэгээд өнгөрсөн жилийн төсөв дээрээс үлдсэн мөнгийг нь энэ 25 оны төсөв дээр нь үлдээчихье. Нэгэнтээ хасаад, бид мөнгө нэмж өгч чадахгүй байгаа юм чинь өнгөрсөн жилийнхийг 1 дүгээр зүйл.

2 дугаар зүйл юу вэ гэхээр Кино урлагийг дэмжих сан мөн ялгаагүй энэ жил төсөв тавигдаагүй байгаа. Өнгөрсөн жилийн төсөв дээрээс үлдсэн мөнгийг нь энэ жилийн төсөв дээр нь үргэлжлүүлээд тавиад өгчихье гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ 2 саналыг манай Байнгын хороон дээр дэмжсэн байсан. Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Бум-Очир гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 3 гишүүн дэмжиж, 13,6 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

5 дахь төсөл, 5 дахь санал. Төсөлд дараах агуулгатай 4 дүгээр зүйл шинээр нэмэх:

4.Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга

хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн Боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй эсвэл Улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж, өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. БСШУС-ын байнгын хороо дэмжсэн санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 27,3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

6 дахь санал. “Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь дэд заалт “а”-аас “сургууль, цэцэрлэг дотуур байрны хоолны материал худалдаж авах” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа. БСШУС-ын байнгын хорооны дэмжсэн санал. Энэ санал болчихсон биз дээ Үүрийнтуяа гишүүнийх тийм ээ? Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 9,1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

7.“Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “а” заалтаас “Боловсролын салбарын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг дотуур байрны хоолны материал худалдаж авах” гэснийг хасаж, “Гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн сурагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах” гэж өөрчлөх. Санал гарган Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. БСШУС-ын байнгын хороо дэмжээгүй санал. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүний саналыг. 22 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжиж, 27,3 хувиар уг санал дэмжигдсэнгүй. Байнгын хороодын саналуудыг хурааж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

7/Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх боломжийг бүрдүүлэх, үүнд шаардлагатай Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 25 оны төсвийн жилд зарцуулахыг даалгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ. Мөнхсоёл гишүүнийг протоколд дэмжсэнээр авъя.

Дараагийн санал, гишүүний гаргасан санал. 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

8/Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалттай шаардлага хангасан барилгыг хууль тогтоомжид нийцүүлэн 5 жилийн дотор өөрийн өмчлөлд эцэслэн шилжүүлж авах нөхцөлтэйгөөр санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, худалдан авахыг Засгийн газарт даалгасугай. Санал гаргасан Г.Дамдинням, Г.Тэмүүлэн. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар уг санал дэмжигдлээ. Одоо 6, 7-хон санал байна гишүүдээ.

Хуулийн төсөлд ажлын хэсгээс дараах саналыг оруулъя.

1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийн код өгөх, дугаар, ангилал, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнтэй уялдуулж, төсөвт өртгийг өөрчлөх. Мөн төслүүдийн зүйл, хэсэг заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдлээ. Тэгэхдээ энэ дээр нэг юм анхаараарай. Тэр төсөвт өртөгтэй холбогдуулаад өөрчлөлт ирүүлэх эрх өгч байгаа байхгүй юу. Тэгэхдээ заавал энэ хураагдсан саналын дагуу шүү. Хураагдсан саналтай холбогдуулж.

Дараагийн санал. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Дараагийн санал. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол. 1.Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 22 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах, санал хураалтыг явуулж дууслаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар. Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.50 цаг

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. 3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 26, 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлэе.

Өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй, зүйл бүрээр хэлэлцэнэ. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй, 2 зүйлтэй юм байна. Тэгээд зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болормаа нэгдсэн хуралдаанд танилцуулна. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.52 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүдээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

